

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

1. **ЕРӨНХИЙ ТОЙМ**
2. **ХЭЛТСЭЭС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БУСАД АЖЛУУД**
3. **ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**
4. **ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**
5. **ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**
6. **ХЯНАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА**
7. **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**
8. **АРХИВ, АЛБАН БИЧИГ ХӨТЛӨЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**
9. **ХЭЛТСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ, ТОД НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ**
10. **СУРГАЛТ, СЕМИНАР БОЛОВСОН ХҮЧНИЙГ БЭХЖҮҮЛЭХ**
11. **СУМДЫН ШИНЭЛЭГ АЖИЛ**
12. **ДҮГНЭЛТ**



1. ЕРӨНХИЙ ТОЙМ

Тус хэлтэс нь 2020 онд Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Иргэний хууль, Зөрчлийн тухай хууль, Татварын ерөнхий хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийн хүрээнд төрийн үйлчилгээг иргэдэд хүргэн ажилласан.

Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хамаарах шинээр батлагдсан болон нэмэлт өөрчлөлт орсон хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд албан хаагчдад сургалт зохион байгуулах, мэдээлэл өгөх, сумдын улсын бүртгэгч нарт холбогдох чиглэлийг тухай бүр хүргүүлэн ажиллаж байна.

Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх “Хөгжлийн хөтөч” үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан хэлтсийн чиг үүрэгт хамаарах үйл ажиллагааны хэрэгжилтийг ханган хуулийн хугацаанд хөтөлбөрийн биелэлтийг аймгийн ЗДТГ-т хүргүүлж ажиллалаа. Мөн аймгийн засаг даргын захирамж, албан даалгаварын хэрэгжилтийг ханган тайланг хуулийн хугацаанд хүргүүлсэн.

2020 онд УБЕГ-ын даргын үндсэн үйл ажиллагаатай холбоотой 22, хүний нөөцтэй холбоотой 7 нийт 28 тушаал, 6 зөвлөмж, 24 чиглэл, албан даалгавар 1, мэдээ судалгаа ирүүлэх тухай хугацаат албан бичиг 37 ирснийг албан хаагчдад танилцуулан хэрэгжилтийг ханган, тайланг хугацаанд нь хүргүүлэн, УБЕГ-с зохион байгуулсан 16 удаагийн цахим сургалтанд хэлтсийн албан хаагчдыг бүрэн хамруулж ажилласанаар мэдээ, мэдээллийг цаг тухайд нь авч ажилласан.

Хэлтсийн 35 албан хаагчийн 2019 оны ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд цахимаар хүлээн авч баталгаажуулах, цаасан хэлбэрээр хүлээн авах, бүртгэх хадгалах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж ажиллалаа. Төрийн албанд шинээр болон өөрчлөгдөн томилогдсон 4 албан хаагчдын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг УБЕГ-т хүргүүлж ажилласан байна.

Шинэ коронавирусын халдварын үед хэлтсийн үйлчилгээний зааланд байрлах зурагт болон хэлтсийн цахим хуудсаар дамжуулан богино хэмжээний зөвлөмжүүдийг иргэдэд хүргэн ажиллахаас гадна хэлтсийн бүх албан хаагчид өөрсдийн цахим хуудсаар дамжуулан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх заавар зөвлөмжийг иргэдэд түгээн ажиллаж байна. Мөн “МАСКАА ЗҮҮЕ” аянд хэлтсийн бүх албан хаагчид нэгдэж, 30 секундын бичлэг бэлтгэн, бусад аймгийн Улсын бүртгэлийн хэлтсүүд болон аймгийн хэмжээн дэх төрийн байгууллагуудыг уриалан ажилласан.

Тус хэлтэс нь “Жендэрт суурилсан хүчирхийлэл”-тэй тэмцэх 16 хоногийн аянд нэгдэн цахим орчинд зурагт хуудас бэлтгэн түгээн, уриалга гарган ажилласан.

Мөн E-Mongolia вэбсайтыг хэрхэн ашиглах талаарх заавар мэдээллийг бэлтгэн хэлтсийн фэйсбүүк , вэб сайт, page хуудсаар түгээсэн бөгөөд албан хаагчид өөр өөрсдийн фэйсбүүк хаягаар түгээж ажилласан байна.

Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан “Зөв зөвд ШУДАРГА ЗӨВ” соён гэгээрүүлэх аянд нэгдэн өөрийн аймгийн болон байгууллагынхаа лого бүхий зурагт хуудас бэлтгэн хэлтсийн фэйсбүүк , вэб сайт, page хуудсаар түгээн, өөрийн байгууллагадаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

2. АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БУСАД АЖЛУУД.

Тус хэлтэс нь эцэг эхийн зөвлөлийг 2019 онд хэлтсийн даргын тушаалаар байгуулсан бөгөөд тус зөвлөл нь 2020 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган батлуулж, төлөвлөгөөний дагуу холбогдох ажлуудыг хийж хэрэгжүүлж тайланг хагарс бүтэн жилээр гарган аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газарт хүргүүлэн ажилласан.

Байгууллагын эцэг эхийн зөвлөлөөс албан хаагчдын хүүхдүүдэд зориулан байгууллагын нэг өрөөг “Хүүхдийн өрөө” болгон тохижуулж, хүүхдүүдэд зориулан оюуны хөгжлийг дэмжих ном сурах бичиг, IQ хөгжүүлэх тоглоом зэрэг зүйлсийг байрлуулан хүүхдүүдийн сурах, амрах орчинг бүрдүүлэн “Нэг Төрийн албан хаагч- нэг ном” аянг өрнүүлж хүүхдийн номын санд 50 орчим ном, тоглоомоор баяжигдсан байна.

Үйлчилгээний заалны зохион байгуулалтыг хангах төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэх зорилгоор “Угтах үйлчилгээний ажилтан”-ыг тогтмол ажиллуулснаар иргэдийн тус байгууллагад өгөх сэтгэл ханамж дээшилсэн.

Хэлтсийн үйлчилгээний заалны ширээ сандлыг иж бүрнээр шинэчилж нийт 1.860.000 төгрөгийг зарцуулсан.

2020 оны оны 3 дугаар сард Коронавирус халдварт өвчний эсрэг болон аймгийн хэмжээнд өвөлжилт хаваржилт хүндэрсэн цаг үед Хэлтсийн зүгээс бүх албан хаагчид 1 өдрийн цалингаа цуглуулж хандивын аянд нэгдэн Аймгийн Онцгой комисст 600 000, Мөрөн сумын шуурхай штабт 200 000, Их-Уул (аймгийн онцгой гишүүний хувиараар ажил үүргийг хариуцсан) сумын шуурхай штабт 400 000 төгрөгийг тус тус хандивлан хамтран ажиллав.

Байгууллагын ёс зүйн зөвлөлийг хэлтсийн тушаалаар 2019 онд байгуулсан бөгөөд тус зөвлөл нь 2020 онд төлөвлөгөө гарган төлөвлөгөөний дагуу хийж хэрэгжүүлэх ажлыг тухай бүр зохион байгуулан ажилласан. Тайлант хугацаанд нийт 6 удаа хуралдаж, нийт албан хаагчдад 2 удаа сургалт зохион байгуулсан байна. Ёс зүйн зөвлөлийн тайланг хагас, бүтэн жилээр гарган УБЕГ-ын ёс зүйн хороонд хүргүүлсэн.

Хөвсгөл аймгийн 23 сум 1 тосгоныг улсын бүртгэлийн нэгдсэн сүлжээнд холбох ажлын хүрээнд 2020 онд зам харилцаа муутай, хамгийн холын сум буюу

Рэнчинлхүмбэ сум, Цагааннуур сум, Улаан-Уул сум, мөн Эрдэнэбулган, Тосонцэнгэл, Их-Уул, Тариалан сумдыг Улсын бүртгэлийн нэгдсэн сүлжээнд холбогдож, аймгийн нийт 22 сумын иргэд иргэний улсын бүртгэлийн үйлчилгээг хамгийн түргэн шуурхай авах боломжтой болсон байна. Үлдсэн Ханх, Шинэ-Идэр түнэл сумдыг онлайн сүлжээнд холбох ажлын бэлтгэл ажлыг бүрэн хангасан ба энэ ондоо багтаж онлайн сүлжээнд холбохоор ажиллаж байна.

Хөвсгөл аймгаас 2020 оныг “Зүтгэл-Итгэл-Санаачилга”-ыг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан “Шилдэг төрийн байгууллага, төрийн албан хаагчийг” шалгаруулах удирдамжийн дагуу хэлтсийн төлөвлөгөө боловсруулан батлуулж, ажлын хэсэг байгуулан, төлөвлөгөөний дагуу ажлуудыг хийж хэрэгжүүлэн, хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.

2020 оны 5 дугаар сарын 05-ны өдөр бүх нийтээрээ мод тарих үндэсний өдрийг тохиолдуулан Мөрөн сумын засаг даргын захирамжаар “Ногоон мөрөн” аяныг зарласан. Уг аяны хүрээнд “Ногоон Мөрөн хотын төлөө” хамтдаа уриан дор албан хаагч бүр нэг нэг мод суулган ногоон байгууламжийн зурвас байгуулан ажилласан байна.

2020 оны 7 дугаар сарын 21-нд 1 дүгээр эмнэлэгийн эмчийг урин авчирч биеийн эрхтэн хянах ситсемийн иж бүрэн шинжилгээ оношилгоог 37 үзүүлэлт 250 зүйлээр хийдэг америкийн хамгийн сүүлийн үеийн дэвшилтэд технологийн “QRMA” аппаратаар 23 албан хаагчдын биеийн эрхтэн системийг иж бүрэн оношуулж, эрүүл мэндийн заавар зөвлөгөөг авсан.

Шинээр томилогдож буй төрийн албан хаагчдыг байгууллагын ёс зүйн хорооны хурлаар оруулж, байгууллагын дотоод журам, үйлчилгээний стандарт, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг танилцуулж, “Төрийн албан хаагчийн тангараг”-ийг өргүүлэн ажлыг нь хүлээлгэн өгч хэвшлээ.

УБЕГ-аас ирүүлсэн “Орон нутаг дахь цахим хуудсын нэгдсэн платормд оруулах бодлого”-ын дагуу Хөвсгөл аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн албан ёсны Вэб сайт хөгжүүлж шинэчлэн мэдээ, мэдээллийг иргэдэд түргэн шуурхай хүргэн ажиллаж байна.

2020 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Хэлтсийн албан хаагчдын дунд “Бүртгэгчийн нэг өдөр” арга хэмжээг зохион байгууллаа. Хэлтсийн удирдах албан хаагчид нэг өдөр ажил үүргээ сольж Хэлтсийн дарга эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгчээр, хяналтын улсын байцаагч эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгчээр, иргэний улсын ахлах бүртгэгч хуулийн этгээдийн улсын бүртгэгчээр, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Мөрөн сумын улсын бүртгэгчээр тус тус ажиллан, ажлын байран дээр гарч буй бэрхшээл, тулгамдаж байгаа асуудлын талаар санал бодлоо солилцон, зохих шийдвэрүүдийг Хэлтсийн даргын зөвлөлөөр шийдүүлж ажилласан байна.

2020 оны 10 дугаар сарын 01-нээс 11 дүгээр сарын 01-ны хооронд “Зөв хандлага зөрчилгүй бүртгэл” сарын аяныг хэлтсийн болон сумдын улсын бүртгэгч

нарын дунд зохион байгуулсанаар байгууллагын хэмжээнд эерэг, дулаан уур амьсгалыг бий болгож, зөрчилтэй бүртгэлийн тоо буурсан үзүүлэлттэй болсон байна.

МУСГЗ Д. Сүрэнжавын нэрэмжит Хөвсгөл аймгийн нийтийн номын сангаас 2020 оны 11 дүгээр сарын 1-нээс 12 дугаар сарын 1-ний хооронд зохион байгуулсан “ДОМОГТОЙ-ХӨВСГӨЛ” аяны хүрээнд хэлтсийн албан хаагч бүр ном хандивлаж, сэтгэлийн дэм өгч ажиллав.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу УБЕГ-ын хяналт шалгалтын газрын дарга Б.Ганзоригор ахлуулсан хяналт шалгалтын ажлын хэсэг тус хэлтэст 2020 оны 8 дугаар сарын 24-ны өдрөөс 27-ны өдрийг дуустал хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд шалгалтын үр дүнгийн талаар зөвлөмж ирүүлсэн. Уг зөвлөмжийн дагуу тус хэлтэс нь дараах ажлуудыг хийж хэрэгжүүллээ.

- Цагийн бүртгэлийг хурууний хээ уншигчаар бүртгэж чөлөөтэй, өвчтэй, ээлжийн амралттай үед нь цаг ашиглалтын дэвтэр давхар хөтлөн, Ковид 19 цар тахал өвчин гарсантай холбогдуулан цагийн бүртгэлийг жижүүрүүд бүртгэж ахлах нягтлан бодогч хяналт тавин ажиллаж байна.
- Албан хаагчид гүйцэтгэлийн тайлангаа сар, улирлаар, жилээр тогтмол гаргаж хэвшсэн бөгөөд тайланг сар, улирал бүр тасгийн дарга нар хүлээн авч дүгнэн, хэлтсийн даргын тушаалаар хяналтын улсын байцаагч Б.Мөнгөнзулаар ахлуулсан ажлын хэсэг сар, улирлаар нь хяналт тавин ажиллаж байна.
- Архивын өрөөнүүдэд түрдэг тэрэг, камер гэх мэт төхөөрөмжүүдийг 2021 оны төсөвт суулган байрлуулахаар төлөвлөсөн.
- Галын буланд байх ёстой багаж хэрэгслүүдийг бүрэн байрлуусан бөгөөд агаар цэвэршүүлэгч нэмж суурилуулсан.
- Серверийн өрөөнд тогтмол чийгтэй цэвэрлэгээ хийж хэвшсэн ба мөн утасны жагсаалт байршуулж шошгожуулалт хийгдсэн.
- Мөн серверийн өрөө хэт хуурайшилттай орчин тул савтай ус байнга байршуулж зохих чийглэгийг өгч байна.

Мөрөн сумын ЗДТГ, Аймгийн ГБХЗХГ, Орхон аймаг дахь Гэр бүлийн ордны хамт олонтой хамтран “Аз жаргалтай гэр бүл” залуу гэр бүлийн гэрлэх ёслол, хүндэтгэлийн арга хэмжээг 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдөр Мөрөн сумын “Ёслол хүндэтгэлийн өргөө”-нд зохион байгуулж 3 гэр бүлийн гэрлэлтийн гэрчилгээг ёслол төгөлдөр гардууллаа. Уг арга хэмжээний зорилго нь шинээр гэр бүл болж, гэрлэлтээ батлуулж буй залуу хосуудаар дамжуулан гэр бүлийн үнэ цэнэ, хайр, харилцаа, өрхийн гишүүдийн бусдынхаа өмнө хүлээх үүрэг хариуцлагыг иргэд, олон нийтэд ухамсарлуулах, тогтвортой, эрүүл гэр бүлийг төлөвшүүлэх, зөв үлгэр дуурайллыг түгээхэд чиглэгдсэн ба арга хэмжээний үр дүнд гэр бүлийн үнэ цэнэ, гэр бүлийн гишүүдийн үүрэг хариуцлагыг залуучуудад

ухамсарлуулж, гэр бүлийн тогтвортой, бат бөх байдлыг хангасан сайхан арга хэмжээ болсон гэж үзэж байна.

2020 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Аймгийн ЗДТГ, Цагдаагийн газартай хамтран зохион байгуулсан “Хөдөлгөөн эрүүл мэнд -10000 алхалт” арга хэмжээнд хэлтсийн хамт олноороо идэвхтэй оролцож, цэвэр агаарт алхаж, дасгал хөдөлгөөн хийн чөлөөт цагаа зөв боловсон нэг өдрийг өнгөрөөсөн байна.

Коронавирус халдвар /Ковид-19/-ын цар тахал дотоодод тархсантай холбогдуулан Монгол улсын засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 178 дугаар тогтоол, Улсын онцгой комиссоос “Гамшгаас хамгаалах тухай хууль”-ийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь заалтын дагуу бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулах гаргасан Улсын бүртгэлийн Ерөнхий газрын 2020 оны 11 дүгээр сарын 12-ны 3/9985 дугаар чиглэлийн дагуу бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд буюу 2020 оны 11 дүгээр 12-ны өдрөөс 12 дугаар сарын 01-ний өдрийн хооронд хэлтсийн албан хаагчид хариуцлагатай жижүүрийн хуваарь гарган батлуулж, хариуцлагатай жижүүрийн үүргийг хийж гүйцэтгэн өдөр тутмын тоон мэдээг тогтоосон хугацаанд УБЕГ-т хүргүүлэн ажилласан байна..

Мөн бүх нийтийн хатуу хол хорио тогтоосонтой холбогдуулан гадуур эргүүл, хяналтын үүргийг хийж гүйцэтгэх албан хаагчдын хуваарийг гарган аймгийн Онцгой байдлын газарт хүргүүлэн 2020 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс 30-ны өдрийг дуустал албан хаагчид эргүүл хяналтын үүргийг хийж гүйцэтгэлээ. Дээрх эргүүл хяналтын үүргийг хийж гүйцэтгэх үүргээс жирэмсэн болон 0-5 насны хүүхэдтэй албан хаагчдыг чөлөөлж ажилласан.

Монгол улсын шадар сайдын 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 150 дугаар тушаал, Аймгийн онцгой комиссын шийдвэрийн дагуу өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлсэн хугацаанд хот хоорондын болон сум хоорондын зорчих постон дээр 24 цагаар ажиллах албан хаагчдын хуваарь гарган 2020 оны 12 дугаар сарын 02-ноос 2020 оны 12 дугаар сарын 09-ны хооронд 24 цагаар эргүүлийн үүргийг хийж гүйцэтгэсэн байна.

3. ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Иргэний улсын бүртгэлийн тасаг нь 2020 онд Монгол улсын Үндсэн хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Гэр бүлийн тухай хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Иргэний улсын бүртгэл хөтлөх журам, Монгол улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх мэдээлэх журам болон бусад холбогдох хууль, журмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн Иргэний улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөө хууль ёсны ашиг сонирхолыг хүндэтгэх, иргэний хувийн нууцыг чандлан хамгаалах зарчим, Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандартыг баримтлан ажиллаж улсын бүртгэлийн байгууллагын эрхэм зорилгын хүрээнд аймгийн нийт сумдад анхан шатны бүртгэлийн үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

Шинээр батлагдсан хууль, дүрэм, журмын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:

Монгол Улсын их хурлын сонгуулийн тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлж, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Иргэний улсын бүртгэл хөлтөх журам болон бусад холбогдох дүрэм журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажиллаж байна.

Иргэний Улсын бүртгэлийн чиглэлээр:

2020 оны 11-р сарын 25 ны байдлаар Төрсний бүртгэл 2511 үүнээс эрэгтэй 1269, эмэгтэй 1242, Гэрлэсний бүртгэл 576 үүнээс анхны гэрлэлт 514, дахин гэрлэлт 62, Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл 150, үүнээс захиргааны журмаар 47, шүүхийн журмаар 103, Үрчилсний бүртгэл 80, Эцэг /эх/ тогтоосны бүртгэл 124, Ургийн овог, эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэл 149, нас барсны бүртгэл 770, бүртгэл хийгдэж цахим мэдээллийн санд баталгаажсан байна.

Хяналтын улсын байцаагчийн дүгнэлт, сум дундын иргэний хэргийн анхан шатын шүүхийн шийдвэрээр 20 иргэний регистрийн дугаарыг өөрчилж, Иргэний Улсын бүртгэлийн мэдээллийн санд дахь төрсний бүртгэлийн санд эцэг /эх/-ийн бүртгэл нь бүртгэгдээгүй болон мэдээлэл нь санд суугдаагүй 110 иргэний бүртгэлийг архиваас татан авч хуулбарлан Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлэн зөрчлийг арилгасан. Мэдээллийн санд болон төрсний бүртгэл, гэрлэлтийн бүртгэлийн дэвтэрт өөрийн нэр, эцэг эхийн нэрийг буруу бичсэн бүртгэлд хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр 20 иргэний бүртгэлд засвар өөрчлөлтийн маягыг бичиж Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлэн зөрчлийг арилгасан. Гэрлэлтийн бүртгэл нь иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд суугдаагүй 48 иргэний бүртгэлийг архиваас татан авч хуулбарлан маягт ХААТР-15 ыг Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлэн санд оруулсан.

Иргэдэд үзүүлэх үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж УБЕГ-с Үндэсний энгийн гадаад паспорт, Иргэний цахим үнэмлэх хэвлэгдэн ирсэн тухай мэдээллийг түргэн шуурхай хүргэж “Иргэн Таны Цахим үнэмлэх /Үндэсний энгийн гадаад паспорт/ хэвлэгдэн ирсэн байна” гэсэн мессеж иргэдийн гар утасруу явуулж хэвшсэн байна.

Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийн чиглэлээр:

Бусад аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн 687 бүртгэл үүнээс насанд хүрсэн 448, арван зургаа ба түүнээс доош насны хүүхэд 239, Сум хооронд шилжин ирсэн 1107 бүртгэл үүнээс насанд хүрсэн 750, арван зургаа ба түүнээс доош насны хүүхэд 357, Баг хооронд шилжин ирсэн 2107 бүртгэл үүнээс насанд хүрсэн 1350, арван зургаа ба түүнээс доош насны хүүхэд 757 иргэний бүртгэл хийгдэж цахим мэдээллийн санд баталгаажсан байна.

Монгол улсын их хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг 2020 оны 02 сарын 01 ний өдрөөс санал авах өдрийн дараах өдөр хүртэл түр зогсоож 23 сумын шилжилт хөдөлгөөний бүртгэлийн дэвтэрийг хааж

үлдэгдэл ИУБ-22 маягтын хамт татан авч лацдан иргэний баримтын архивт хадгалаж Монгол улсын их хурлын сонгуулийн дараа өдөр сумын Улсын бүртгэгч нарт хүлээлгэн өгч ажилласан байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг 2020 оны 08 сарын 14 ний өдрөөс санал авах өдрийн дараах өдөр хүртэл түр зогсоож 23 сумын шилжилт хөдөлгөөний бүртгэлийн дэвтэрийг хааж үлдэгдэл ИУБ-22 маягтын хамт татан авч лацдан иргэний баримтын архивт хадгалаж Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн дараа өдөр сумын Улсын бүртгэгч нарт хүлээлгэн өгч ажилласан байна.

Биеийн давхцахгүй өгөгдөлийн бүртгэл буюу Иргэний үнэмлэх олголт:

Биеийн давхцахгүй өгөгдөлийн бүртгэл буюу цахим үнэмлэх олголтын 5412 бүртгэл үүнээс шинэ 1567, хаяж үрэгдүүлсэн 1036, Овог, нэр солисон 2, Хүчинтэй байдлаа алдсан 1, Дүр төрхийн өөрчлөлт орсон 14, Хорин таван насны сунгалт хийлгэсэн 1443, Дөчин таван насны сунгалт 1349 бүртгэл хийгдэж сумын Улсын бүртгэгч нараас ирүүлсэн ИШБүртгэлд хамрагдсан иргэдийн мэдээлэл бүхий 400 DVD хүлээн авч цахим мэдээллийн сад тусган 4373 иргэний цахим үнэмлэхний зураг засч сүлжээнд оруулан хэвлүүлсэн байна.

Хурууны хээ давхардсан, нэрийн толинд нэр баталгаажуулахгүй, ургийн овог, эцэг, эхийн нэр өөрийн нэр зөрүүтэй 96 иргэний мэдээллийг ИУБГ-т хүргүүлэн зөрчил арилгаж иргэний цахим үнэмлэх хэвлүүлэн ажилласан байна.

Шинээр иргэний үнэмлэх авах насад хүрсэн мөн 25 ба 45 насны сунгалт хийлгэх насад хүрсэн боловч хүндэтгэн үзэх шалтгааны улмаас өөрийн биеэр ирж биеийн давхцахгүй өгөгдөлийн бүртгэлд хамрагдах боломжгүй иргэдийг тухайн байгаа газарт нь очиж ИШБүртгэлд хамруулан бичиг баримтжуулах ажлыг тогтмол зохион байгуулж байна.

Гадаадад зорчих эрхийн бүртгэлийн хүрээнд:

Дэлхий нийтэд цар тахал дэгдсэнтэй холбоотой үндэсний энгийн гадаад паспортын захиалга эрс буурч нийт 670 иргэний гадаад паспортын захиалга авч баталгаажуулан УБЕГазарт хүргүүлсэн бөгөөд хил орчмын нутаг дэвсгэрт хялбарчилсан журмаар зорчих үнэмлэх олгох буюу ОХУ-ын хавсралтыг 316 иргэнд олгосон байна. мөн УБЕГ-с Үндэсний энгийн гадаад паспорт хэвлэгдэн ирсэн тухай мэдээллийг түргэн шуурхай хүргэж “Иргэн Таны Үндэсний энгийн гадаад паспорт хэвлэгдэн ирсэн байна” гэсэн мессеж иргэдийн гар утасруу явуулж хэвсгэсэн байна.

Иргэний баримтын архивын ажлын хүрээнд:

Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс

Тайлант хугацаанд тус хэлтсийн иргэний баримтын архивын лавлагааг иргэдэд 8656, хууль хяналтын байгууллага болон бусад байгууллагад 908 лавлагааг олгож Иргэний баримтын архивт иргэний улсын бүртгэлийн 4360 ИУБ маягтуудын баяжилт хийж хураасан бөгөөд үүнд Төрсний бүртгэл /ИУБ-11/ 2511, Үрчилсний бүртгэл /ИУБ-12/ 80, Ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл /ИУБ-13/ 149, Эцэг тогтоосны бүртгэл /ИУБ-14/ 124, Гэрлэсний бүртгэл /ИУБ-15/ 576, Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл /ИУБ-16/ 150, Нас барсны бүртгэл /ИУБ-18/ 770, Биеийн давхцахгүй өгөгдөлийн бүртгэл /ИУБ-31/ 5412 маягт мөн бусад аймаг, нийслэлийн иргэний баримтын архиваас нийт 687 иргэний хувийн хэрэг шилжин ирсэнийг архивт баяжилт хийсэн ба бусад аймагт бүртгэл хийлгэсэн 354 иргэний хувийн хэргийг татан авч иргэний баримтын архивт баяжилт хийсэн байна.

Иргэний улсын бүртгэл хөтлөх журмын 22.5 д заасны дагуу Иргэний улсын бүртгэлд бүртгүүлэхээр хууль тогтоомжид заасны дагуу бүрдүүлсэн баримт бичгийг 23 сум 1 тосгоны улсын бүртгэгч нараас татан авч хадгаламжийн нэгж үүсгэн архивт байршуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Захиалгын хуудсаар нийт 442 иргэний хувийн хэргийг Хяналтын улсын байцаагч, Улсын ахлах бүртгэгч, Улсын бүртгэгч нарт шилжүүлэн өгч хүлээн авсан байх бөгөөд архивын хадгалалт хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангаж архивт хөтлөгдвөл зохих дэвтрүүдийг хөтөлж хэвшсэн.

Арван зургаан нас хүрч иргэний шинэчидсэн бүртгэлд хамрагдсан нийт 1567 иргэний ХААТР-11 маягт болон бусад хобогдох маягтыг ИУБ-31 маягтад хавсарган шинээр хувийн хэрэг үүсгэн галигийн дагуу иргэний баримтын архивт байршуулж, иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд өөрийн болон эцэг, эхийн мэдээлэл нь зөрүүтэй 56 иргэний мэдээллийг холбогдох бүртгэлээс хуулбарлан Улсын бүртгэгч нарт хүлээлгэн өгч зөрчил арилган ажилласан байна.

Иргэний баримтын архивт хадгалагдаж байгаа, мэдээллийн санд тодорхойгүй төлөвтэй 2316 иргэний ХААТР-1 маягт болон 9803 иргэний ХААТР-7 маягтыг галиглаж цэгцлэх ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

2020 оны 09 сарын 18-20 өдрүүдэд Хяналтын улсын байцаагч, Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга, хэлтсийн улсын бүртгэгч нар сумдын хэсгийн хороодод сонгогчийн нэрийн жагсаалт хүргэх ажлаар явахдаа 4 баг болон хуваагдан сумын улсын бүртгэгч нарын ажлыг шалгаж зөвлөгөө өгөн, гарсан зөрчлийг арилгаж, улсын бүртгэлийн багц хуулийн ойлголтын зөрүүг арилгах хэлэлцүүлэг өрнүүлж ажилласан байна.

2020 оны Монгол улсын их хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийг хэргэжүүлж ажиллах ажлын хүрээнд:

Монгол улсын их хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийг хэргэжүүлж ажиллах ажлын хүрээнд Монгол улсын их хурлын сонгуулийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу аймгийн бүх сумдын ИТХ-н тогтоол хуулийн

хугацаандаа Улсын бүртгэлийн хэлтэст бүрэн ирүүлсэн байна. ИТХ-ын тогтоолын дагуу санал авах байр буюу түүнд хамаарах хаягийн мэдээлэл хэсгийн төвийг Иргэний улсын бүртгэлийн системд бүрэн шивж дууссан ба алдаатай болон дутуу мэдээллийг нягтлан шалгаж ажилласан байна.

Монгол улсын их хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг 2020 оны 02 сарын 01 ний өдрөөс санал авах өдрийн дараах өдөр хүртэл түр зогсоож 23 сумын шилжилт хөдөлгөөний бүртгэлийн дэвтрийг хааж үлдэгдэл ИУБ-22 маягтын хамт татан авч лацдан иргэний баримтын архивт хүлээлгэн өгсөн.

Монгол улсын их хурлын сонгуулийн тухай хуулийн 13.3 заасны дагуу нэг хэсэгт байх сонгогчийн тоо 200 -гаас доош байгаа Эрдэнэбулган сумын Удган 5-р багийг Булган тал 2-р багтай нэгтгэж Алаг-Эрдэнэ сумын 6-р баг хатгал тосгон 3 хэсэгт хувааж аймгийн хэмжээнд 129 сонгуулийн санал авах хэсэг байгуулсан байна.

Монгол улсын их хурлын сонгуулийн тухай хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу санал авах байрны дэргэд ажиллах Улсын бүртгэлийн байгууллагын 144 итгэмжлэгдсэн ажилтны судалгааг гаргаж Аймгийн тагнуулын хэлтэст хүргүүлэн тус хэлтсийн саналыг үндэслэн 144 итгэмжлэгдсэн ажилтантай гэрээ байгуулж, нууцын баталгаа гаргуулан авсан болно.

Монгол Улсын их хурлын сонгуулийн бэлтгэл ажил, сонгуулийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудад зориулсан эрх зүйн сургалтыг Улсын бүртгэлийн хэлтсээс 2020 оны 05 сарын 19-21 ний өдрүүдэд Хөвсгөл аймгийн 23 сумыг 3 хэсэгт хувааж онлайн хэлбэрээр зохион байгуулсан байна.

Монгол улсын их хурлын сонгуулийн тухай хуулийн 20.9 д заасны дагуу УБЕГ-аас эрх олгосон улсын бүртгэгч нар СНЖ-г хэвлэж сумдын сонгуулийн хороодод хүлээлгэн өгөх ажлыг хуулийн хугацаанд амжилттай зохион байгуулсан.

Монгол улсын их хурлын сонгуулийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу сонгогч шилжих хөдөлгөөний бүртгэлийг хийж сонгогч шилжин ирсэн, шилжин явсан, түр хасав төлөв сэргээсэн, иргэний бүртгэлтэй холбоотой өөрчлөлтөөр нийт 129 хэсгийн хорооны 1458н лавлагаа хэвлэгдэж СНЖ-д өөрчлөлт оруулсан байна.

Монгол улсын их хурлын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хөвсгөл аймгийн хэмжээнд 23 сумын 129 хэсэгт ажиллах 144 Итгэмжлэгдсэн ажилтны сонгуулийн ирц бүртгэлийн программын дадлага олгох сургалтыг Иргэний улсын бүртгэлийн газрын ахлах мэргэжилтэн Н.Наранцэцэгээр ахлуулсан ажлын хэсэг УБХ-тэй хамтран 2020 оны 06 сарын 11-13 ны хооронд амжилттай зохион байгуулж, сонгогч шилжилт хөдөлгөөн, түр хасав төлөв

сэргээсэн, Иргэний бүртгэлтэй холбоотой өөрчлөлтүүдээ тусгаж СНЖ-ыг эцсийн байлаар хэвлэн Итгэмжлэгдсэн ажилтан болон сонгуулийн хороонд хүлээлгэн өгсөн байна.

2020 ны 6-р сарын 24 ний өдөр тус хэлтсийн шуурхай баг хөвсгөл аймгийн 129 хэсгийн хорооны 144 итгэмжлэгдсэн ажилтанд чиглэл өгч ажиллан 2020 оны Монгол улсын их хурлын ээлжит сонгуулийг амжиттай зохин байгуулж, 2020 оны 06 сарын 25-26 ны өдөр Хөвсгөл аймгийн 129 хэсгийн хорооны 144 итгэмжлэгдсэн ажилтны тоног төхөөрөмж хүлээн авч УБЕГазарт хүргүүлсэн ба СНЖ, бүртгэлийн хуудас, мэдээ тайланг Иргэний баримтын архивт хадгалаж байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах ажлын хүрээнд

2020 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу 23 сумдын ИТХ-н тогтоол хуулийн хугацаандаа Улсын бүртгэлийн хэлтэст бүрэн ирүүлсэн байна. ИТХ-ын тогтоолын дагуу санал авах байр буюу түүнд хамаарах хаягийн мэдээлэл хэсгийн төвийг Иргэний улсын бүртгэлийн системд бүрэн шивж дууссан ба алдаатай болон дутуу мэдээллийг нягтлан шалгаж ажилласан.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг 2020 оны 08 сарын 14 ний өдрөөс санал авах өдрийн дараах өдөр хүртэл түр зогсоож 23 сумын шилжилт хөдөлгөөний бүртгэлийн дэвтэрийг хааж үлдэгдэл ИУБ-22 маягтын хамт татан авч лацдан иргэний баримтын архивт хадгалаж байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 13.3 заасны дагуу Алаг-Эрдэнэ сумын 6-р баг хатгал тосгон 3 хэсэгт хувааж аймгийн хэмжээнд 130 сонгуулийн санал авах хэсэг байгуулсан байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу санал авах байрны дэргэд ажиллах Улсын бүртгэлийн байгууллагын 131 итгэмжлэгдсэн ажилтны судалгааг гаргаж Аймгийн тагнуулын хэлтэст хүргүүлэн тус хэлтсийн саналыг үндэслэн 131 итгэмжлэгдсэн ажилтантай гэрээ байгуулж, нууцын баталгаа гаргуулан авсан болно.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, түүнтэй холбоотой хууль тогтоомжийг нэг мөр ойлгон хэрэгжүүлэх, санал авах өдөр сонгогчийн бүртгэлийг нягтлан шалгахтай холбоотой анхаарах асуудлуудын талаар Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтсээс 130 хэсгийн хороонд ажиллах 131 итгэмжлэгдсэн ажилтанд эрх зүйн цахим сургалтын

хөтөлбөрийг боловсруулан 2020 оны 09 дугаар сарын 11-ний өдөр амжилттай зохион байгууллаа.

Сургалтыг Улсын бүртгэлийн ерөнхий газраас бэлтгэн ирүүлсэн хичээлийн дагуу хэлтсийн дарга Б.Эрдэнэбилэг, иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Б.Өлзийням, Хөвсгөл аймаг дахь тагнуулын байгууллагын ажилтан Г.Түмэнжаргал нар удирдан явууллаа.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйл, 20.9 дахь хэсэгт заасны дагуу, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газрын даргын 2020 оны 9 сарын 7 ны өдрийн 5/7943 дугаартай “Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах тухай” чиглэлийн хүрээнд Хөвсгөл аймгийн 23 сумын 130 хэсгийн сонгогчдын нэрсийн жагсаалтыг 2020 оны 9 сарын 17 ны өдрийн 08:30-13:00 цагийн хооронд бүрэн хэвлэж дууссан байна.

Сонгогчдын нэрсийн жагсаалтыг хуулийн хугацаанд хүргүүлэх ажлыг зохион байгуулахдаа Хөвсгөл аймгийн 23 сумыг 5 хэсэгт хуваан 2020 оны 9 сарын 18-20 ны хооронд сумын сонгуулийн хороо болон итгэмжлэгдсэн ажилтан нарт хүлээлгэн өгсөн ба АНСДИТХСТХууль, Аймаг, нийслэл сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн сонгуулийн сонгогчдын нэрсийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх журмыг анхаарч ажиллах талаар тухайн сумын сонгуулийн хорооны нийт гишүүд болон итгэмжлэгдсэн ажилтнуудтай харилцан мэдээлэл солилцох ажлыг зохион байгуулан ажилласан байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 20.9.1-20.9.5 дахь хэсэг, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн сонгогчдын нэрсийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх журмын 3.5 дахь хэсэгт тус тус заасны дагуу сонгогчдын нэрсийн жагсаалтад өөрчлөлт оруулах лавлагааг хэвлэх ажлыг хийж гүйцэтгэж нийт 41 хэсгийн хорооны 64 лавлагаа хэвлэгдэж СНЖ-д өөрчлөлт оруулсан байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хөвсгөл аймгийн хэмжээнд 23 сумын 130 хэсэгт ажиллаж 131 Итгэмжлэгдсэн ажилтны сонгуулийн ирц бүртгэлийн программын дадлага олгох сургалтыг Эд хөрөнгийн газрын дарга Б.Ариунболдоор ахлуулсан ажлын хэсэг УБХ-тэй хамтран 2020 оны 10 сарын 02-03 ны хооронд амжилттай зохион байгуулж, сонгогчдын нэрсийн жагсаалтад оруулах өөрчлөлтүүдээ тусгаж СНЖ-ыг эцсийн байлаар хэвлэн Итгэмжлэгдсэн ажилтан болон сонгуулийн хороонд хүлээлгэн өгсөн байна.


2020 ны 10-р сарын 15 ны өдөр тус хэлтсийн шуурхай баг хөвсгөл аймгийн 130 хэсгийн хорооны 131 итгэмжлэгдсэн ажилтанд чиглэл өгч Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийг амжилттай зохион байгуулж, Хөвсгөл аймгийн 130 хэсгийн хорооны 131 итгэмжлэгдсэн ажилтны тоног


Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс

төхөөрөмжийг УБЕГ-т хүлээлгэн өгөн, СНЖагсаалт, нээлтийн тайлан, явцын тайлан, хаалтын тайланг хэлтсийн Иргэний баримтын архивт хадгалаж байна.

УБЕГ-ын даргын тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу Хяналт шалгалтын газрын дарга Б.Ганзоригоор ахлуулсан ажлын хэсэг 2020.08.23-25-ны өдрүүдэд тус хэлтсийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн. Уг шалгалтаар иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 5ш зөрчил илэрснийг засч залруулан зөрчлийг арилгасан тухай илтгэх хуудсыг УБЕГ-ын Хяналт шалгалтын газар хүргүүлж ажилласан.

Иргэний улсын бүртгэлийн сүүлийн 5 жилийн судалгааг графикаар харуулав:







4. ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тус хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасаг нь тайлант хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль, Улсын тэмдэгтийн тухай хууль, Газрын тухай хууль, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Татварын ерөнхий хууль, Иргэний хууль, нотариатын тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, УБЕГ-аас ирүүлсэн чиглэл, журмын хүрээнд эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэж нийт **10380** мэдүүлэг хүлээн авч ажиллалаа.

Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2019.07.03-ны А/685 дугаар тушаалаар батлагдсан “Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандарт”, 2019.01.23-ний өдрийн засгийн газрын тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Шинээр батлагдан гарсан хууль, тогтоомж болон цаг үеийн үйл ажиллагаатай холбогдуулан Улсын бүртгэлийн ерөнхий газар, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн чиглэл, дүрэм журмуудыг уншиж судлан хэрэгжилтийг ханган холбогдох ажлуудыг зохион байгуулж ажиллалаа.

Иргэдээс ирүүлсэн хүсэлт холбогдох баримт бичгийг үндэслэн “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль”-ийн 14 дүгээр зүйлийн 14.1.7-д

заасан шалтгаанаар иргэдийн хүсэлт холбогдох баримт бичгийг үндэслэн 32 ширхэг хувийн хэргийг хаах мэдүүлгийг хүлээн авч улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаалаар хувийн хэрэг бүртгэлийг хаасан байна. Иргэн хуулийн этгээдийн өргөдөл хүсэлт, нотлох баримтыг үндэслэн УБЕГ-ын даргын тушаал, хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр нийт 31 ширхэг гээгдүүлсэн гэрчилгээг бичиж иргэдэд дахин олголоо. Тайлант хугацаанд жилийн эцсийн байдлаар эд хөрөнгийн бүртгэлийг ангилан авч үзвэл:

Газар өмчлөх эрх болон газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг анх удаа баталгаажуулах:

Газар өмчлөх эрх болон газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн анхны бүртгэлийн үйчилгээг ажлын 5 хоногт багтаан бүртгэж ажиллалаа. Тайлант хугацаанд газар өмчлөх эрхийн бүртгэл нийт **542**, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн анхны бүртгэл **727**-ийг бүртгэж, ерэгс программд оруулж, нийт **1269** ширхэг шинэ хувийн хэрэг үүсгэн архивт байрлуулсан байна.

Барьцааны бүртгэл: /ипотек/

Барьцааны гэрээний бүртгэлийн энгийн үйлчилгээг ажлын 3 хоногийн дотор, яаралтай үйлчилгээг ажлын 4 цагт багтаан бүртгэдэг ба иргэд ихэвчлэн яаралтай үйлчилгээг авдаг болно. Тайлант хугацаанд барьцааны нийт **7484** мэдүүлэг хүлээн авч бүртгэсэн ба үүнээс барьцааны гэрээ **4207**, барьцааны гэрээ дуусгавар болгох **3277** -ийг хүлээн авч бүртгэсэн байна.

Гэрээний эрхийн бүртгэл:

Гэрээний эрхийн бүртгэлийн энгийн үйлчилгээг ажлын 5 хоногт, яаралтай үйлчилгээг ажлын 4 цагт багтаан бүртгэж байна. Тайлант хугацаанд газар болон үл хөдлөх эд хөрөнгийн гэрээний эрхийн бүртгэл нийт **1174** -г бүртгэсэн байна. Үүнээс бэлэглэлийн гэрээгээр 117, ХХАГ-ээр 748, арилжааны гэрээгээр 14, өв залгамжлах эрхийн бүртгэл 129, шүүхийн шийдвэрээр 2, хамтран өмчлөгч өөрчлөгдөх бүртгэлээр 159, бусад гэрээ хэлцлээр 5 бүртгэл тус тус бүртгэсэн байна.

Лавлагаа хуулбар олголт:

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн лавлагааны яаралтай үйлчилгээг ажлын 8 цагт, энгийн үйлчилгээг ажлын 5 хоногийн дотор гарган иргэдэд үйлчилж ажиллалаа. Тайлант хугацаанд Газар өмчлөх эрх болон газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн нийт 134 лавлагаа, хуулбар 5, тус тус олгосон байна.

Газар эзэмших, ашиглах эрхийн бүртгэл:

Тайлант хугацаанд газар эзэмших эрхийн 2328 бүртгэл, ашиглах эрхийн 1 бүртгэлийг улсын бүртгэлд бүртгэж бүртгэлийн нийт 2329 дугаар олгогдсон бөгөөд 738 эзэмших эрхийн бүртгэлийг бүртгэхээс татгалзсан тоон үзүүлэлттэй байна.

Архив, мэдээллийн сангийн талаар:

Тайлант хугацаанд 9111 хувийн хэрэгт үйлчилгээ орсон бөгөөд тус үйлчилгээгээр 204 055 596 / хоёр зуун дөрвөн сая тавин таван мянга таван зуун ерэн зургаан / төгрөгийн мөнгөн орлогыг төвлөрүүлэн ажиллалаа. Шинээр 1269 хувийн хэрэг нээж эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн бүртгэлийг архивт хүлээн авсан .

Хөрөнгөгүй лавлагааг 250 нэгж үүсгэн багцалж үдэн архивын санд байршуулсан болно.

Тус тасаг нь Монгол улсын засгийн газраас хэрэгжүүлсэн “Ухаалаг засаглал” төслийн хүрээнд цахимжилтын ажлыг амжилттай дуусган eprs1, eprs2 , газрын дундын мэдээллийн сан зэрэг програмуудад амжилттай шилжсэн. Мэдээлэл технологийн ажилтантай хамтран дээрх программ тус бүрийн аюулгүй байдлыг ханган өдөр тутамдаа ашиглан бүртгэлийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

Архивт сард 3 удаа чийгтэй цэвэрлэгээг хийлгэхээс гадна, байх ёстой галын хорыг шинэчилэн бусад аюулгүй байдлын багаж, хэрэгслийг байршуулан архивын стандартыг ханган ажиллаж байна.

Өргөдөл гомдол, мэдээ тайлан, хугацаатай албан бичгийн шийдвэрлэлт:

Тайлант хугацаанд эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн талаарх тоон мэдээг хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгон эд хөрөнгийн бүртгэл, цахимжуулалтын газарт хүргүүлж ажиллалаа.

Эрх бүхий албан тушаалтан, хууль хяналтын байгууллагаас нийт 114 албан бичиг ирүүлсний дагуу хариуг цаг хугацаанд нь хүргүүлсэн байна.

Бусад ажлын хүрээнд:

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлтэй холбоотой мэдээ мэдээлэл, шинэчлэн болон өөрчлөгдөн гарсан хууль тогтоомж, хурам чиглэлийн дагуу болон цахимжилтын ажлын явц, e-barimt-ийн ач холбогдол үр дүн зэргийг цаг тухай бүрт нь мэдээлж тайлант хугацаанд орон нутгийн телевизээр 3 удаа, facebook болон байгууллагын вэб сайтаар байнгийн мэдээллээр ханган ажилласан. .

2020 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр Хөвсгөл аймаг дахь ШШГГ, аймгийн Иргэний хэргийн анхан шатны шүүх, Улсын бүртгэлийн хэлтсийн хооронд зохион байгуулсан хэлэлцүүлэгт оролцон мэдээлэл хийж санал солилцлоо. Уг хэлэлцүүлгээр тулгамдаж буй асуудал, шүүхийн шийдвэрийн шинэчилэгдсэн хуулийн хүрээнд хуулийг нэг мөр ойлгох, хуулийн хяналтын болон төрийн захиргааны байгууллагын хоорондын уялдаа холбоог сайжруулах чиглэлээр харилцан тохиролцон хамтран ажиллаж байна.

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хууль, Монгол улсын хаягжуулалтын тухай хууль, Монгол улсын засгийн газрын 2013 оны 280 тоот тогтоолоор батлагдсан “Гудамж, зам талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам”-ыг тус тус хэрэгжүүлэх үүднээс сумдын газрын даамлуудаас хаяг

өөрчилсөн, олгосон тухай иргэдийн хурлын тогтоолыг татан авч, тогтоолын дагуу үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээний хаягийг олгох ажлыг зохион байгуулж ажилласан байна.

УБЕГ-ийн Хяналтын газраас ирүүлсэн зөрчил засах тухай чиглэлийн дагуу Хөвсгөл аймгийн хэмжээнд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим систем /EPRS/-д бүртгэлийн төрөл буруу сонгосон төлөвтэй төрөөс хувьчилсан газар өмчлөх эрхийн бүртгэл 2, газраас бусад үл хөдлөх хөрөнгийн бүртгэл 19, нийт 21ш хувийн хэрэг бүртгэлийг эх нотлох баримт буюу цаасан суурьт баримт, цахим системтэй тулган нягталж Хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулан /EPRS/-д 20ш хувийн хэрэг бүртгэлийн төлвийг засч өөрчлөн цахим систем /EPRS/-д орууллаа.

УБЕГ-ийн Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн 2020 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 7/1960 дугаартай чиглэлийн дагуу Хөвсгөл аймгийн хэмжээнд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим систем /EPRS/-д үл хөдлөх эд хөрөнгийг эрхийн улсын бүртгэлд бүртгэхдээ газрын нэгж талбарын дугаарыг цахим мэдээллийн санд тусгаагүй нийт 79 хувийн хэрэг бүртгэлийг эх нотлох баримттай, тулган шалгаж нэгж талбарын дугаарын жагсаалт үйлдэн хяналтын улсын байцаагчаар дүгнэлт гаргуулан 77ш хувийн хэрэг бүртгэлийн зөрчлийг арилган нэгж талбарын дугаарыг цахим систем /EPRS/-д оруулсан байна.


Хөвсгөл аймгийн хэмжээнд хилийн цэс зөрчин нийт 229 иргэний нэр дээр монгол улсын иргэнд газар өмчлүүлэхээр тухайн шатны засаг даргын захирамж гарсан байсан. Энэхүү ажлын хүрээнд аймгийн засаг даргын 2020.03.31-ны өдрийн А/193 дугаартай захирамж гарч ажлын хэсэг байгуулагдан ажилласан ба уг иргэдийн нэр дээрх өмчлөх эрхийг хаяг болон рд-аар Eprs програмд шүүж үзэхэд бусдад гэрээ хэлцэлээр шилжсэн 70ш хувийн хэрэг бүртгэл, зээлийн гэрээнд бүртгэгдсэн 75ш хувийн хэрэг бүртгэл, газар өмчлөх эрхийн 204ш хувийн хэрэг бүртгэл, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 97ш өмчлөх эрхийн хувийн хэрэг бүртгэл, нийт 301ш хувийн хэрэг бүртгэлийн улсын дугаар, хаяг, нэгж талбарын дугаар солигдох ажлыг эд хөрөнгийн газартай хамтран ажиллаж байна.

УБЕГ-ын даргын тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу Хяналт шалгалтын газрын дарга Б.Ганзоригоор ахлуулсан ажлын хэсэг 2020.08.23-25-ны өдрүүдэд тус хэлтсийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн. Уг шалгалтаар эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 537ш хувийн хэргийг татан авч шалгасан бөгөөд 15 зөрчил илэрснийг засч залруулан зөрчлийг арилгасан тухай илтгэх хуудсыг УБЕГ-ын Хяналт шалгалтын газар хүргүүлж ажилласан.


Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс

УБЕГ-ын даргын 2020 оны А/1272 дугаар тушаалаар байгуулагдсан “Монгол Улсад бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний 80 жилийн ой тэмдэглэн өнгөрүүлэх” ажлын хүрээнд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасаг “Улсын бүртгэгчийн нэг өдөр” “Зөв хандлага зөрчилгүй бүртгэл” зэрэг аяныг санаачлан зохион байгуулан, иргэдээс сэтгэл ханамжийн судалгааг авч үр дүнг нэгтгэн ажилласан байна.

Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийг анх удаа бүртгэх бүртгэлийн тоон үзүүлэлтийг сүүлийн 3 жилээр харьцуулбал:



Газар өмчлөх эрхийг анх удаа бүртгэх бүртгэлийн тоон үзүүлэлтийг сүүлийн 3 жилээр харьцуулбал:





5. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тус хэлтсийн хуулийн этгээдийн бүртгэл нь Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн

бүртгэлтэй холбоотой хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журам, Хуулийн этгээдийн нэр олгох, баталгаажуулах журам, Иргэн, хуулийн этгээдийн тамга тэмдэг баталгааны тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журам болон бусад холбогдох хууль, журам, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Иргэний хууль, Нотариатын тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, чиглэл, журмын хүрээнд хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэж нийт 212 хуулийн этгээдийн нэрийг баталгаажуулж, 1389 иргэн хуулийн этгээдийн материал хүлээн авч ажилласан байна.

Хуулийн этгээд шинээр үүсгэн байгуулах бүртгэл:

Шинээр 139 хуулийн этгээдийн нэрийг баталгаажуулан, шинээр үүсгэн байгуулагдсан 139 хуулийн этгээдийн материалыг хүлээн авч улсын бүртгэлд бүртгэж хувийн хэрэг нээн архивт хүлээлгэн өглөө. Үүнд:

- Хязгаарлагдмал хариуцлагатай компани 108,
- Хоршоо 1,
- Сан 1,
- Төрийн бус байгууллага 20,
- Үйлдвэрчний эвлэлийн байгууллага 1,
- Шашны байгууллага 6,
- Хадгаламж зээлийн хоршоо 1,
- Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдэврийн газар 1-ыг газрыг тус тус бүртгэж хувийн хэрэг үүсгэж цахимжуулан архивт хүлээлгэн өгсөн байна.

Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн бүртгэл:

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн өөрчлөлт 830-г хүлээн авснаас

- Хуулийн этгээдийн бүртгэлийн гэрчилгээгээ гээгдүүлсэн буюу гэмтээсэн бусад шалтгаанаар 42,
- Хуулийн этгээдийн эрх шилжүүлэх болон өв залгамжлагчаар үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн, хаяг, дүрмийн сан, гишүүн нэмэх хасах, эцсийн өмчлөгч нөхөн бүртгүүлэх болон бусад шалтгаанаар бүртгэлийн мэдээлэлдээ өөрчлөлт оруулсан 744,
- татан буугдсан 44-н хуулийн этгээдийн холбогдох материалыг хүлээн авч бүртгэн хувийн хэрэгт баяжилт хийн цахимжуулан архивт хуулийн хугацаанд хүлээлгэн өглөө.

Дээрх нэмэлт өөрчлөлтийн бүртгэлийн 652 нь эцсийн өмчлөгчийг нөхөн бүртгэсэн бүртгэл байна.

Иргэн хуулийн этгээдийн лавлагаа, хуулбар

Хуулийн этгээдийн лавлагаа

- Хуулийн этгээдтэй эсэх талаар иргэнд лавлагаа 58,
- Хуулийн этгээдийн лавлагаа 7
- Төрийн байгууллагад лавлагаа 24 нийт 89 лавлагаа олгосон байна.

Хуулийн этгээдийн хувийн хэргээс хуулбар

- Иргэн хуулийн этгээдэд хуулбар 30,
- Төрийн байгууллагад хуулбар 6 нийт 36 хуулбар олгосон байна.

Архив, мэдээллийн сан

2020.11.25 байдлаар хуулийн этгээдийн архивт цахим санд бүртгэлтэй 2440, татан буугдсан 267, шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй 155, нийт 2862 хуулийн этгээдийн хувийн хэрэг байршиж байна.

Шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй 155

- Хязгаарлагдмал хариуцлагатай компани 41,
- Хувьцаат компани 1,
- Төрийн бус байгууллага 48,
- Хоршоо 2,
- Сан 4,
- Хэвлэл мэдээллийн хэрэгсэл 26,
- Бүрэн бус хариуцлагатай компани 9,
- Шашны байгууллага 2,
- Үйлдвэрчний эвлэлийн байгууллага 18,
- Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар 1,
- Хувиараа эрхлэх аж ахуй 2,
- Нөхөрлөл 1,

Цахим санд бүртгэлтэй 2407 хуулийн этгээд,

- Хориг тавиулсан 3,
- Татан буугдсан 267,
- Хэвийн үйл ажиллагаа явуулж байгаа 2437 хуулийн этгээд тус тус бүртгэлтэй байна.

Иргэн хуулийн этгээдийн тамга, тэмдэг баталгааны тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох

Иргэн хуулийн этгээдийн тамга, тэмдэг баталгааны тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журмын дагуу 175 –н хуулийн этгээдийн болон хуулийн этгээдийн эрхгүй этгээдэд тэмдэг, баталгааны тэмдэгийн хяналтын дугаарыг олгож 2020 оны 11 сарын 25-ны байдлаар татан буугдсан, хэлбэр ашиглалтын шаардлага хангахгүй болон бусад шалтгаанаар хураагдсан 109 ширхэг хуулийн этгээдийн тамга тэмдэг, баталгааны тэмдгийг хураан авсан байна. 2020 онд жилийн байдлаар 67 ширхэг тамга тэмдгийг хуулийн хугацаанд нь устган, 42 ширхэг хуулийн этгээдийн тамга тэмдэг, баталгааны тэмдгийг

журмын дагуу хадгалалт хамгаалалтын шаардлага хангасан сейф шүүгээнд хадгалаж байна.

Мэдээ тайлан, хугацаатай албан бичгийн шийдвэрлэлт

Сар бүрийн 25-наар тасалбар болгон хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээ, архивын мэдээ, үнэт цаасны тайлан, орлогын мэдээ, архивын орлогын мэдээг батлагдсан маягтын дагуу хуулийн хугацаанд үнэн зөв гаргаж холбогдох албан тушаалтанд цахимаар болон цаасаар хүргүүлэн ажиллаж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн хариутай албан бичгийг тогтоосон хугацаанд холбогдох мэдээ мэдээллийг хүргүүлэн ажиллаж байна.

Хууль хяналтын болон төрийн байгууллагаас ирүүлсэн 24 хугацаатай албан бичигт хуулийн хугацаанд хариу өгч холбогдох материалыг хувийн хэрэгт хавсарган архивт хүлээлгэн өгч ажилласан.

Орон нутгийн болон бүртгэлийн хэлтсийн дансанд төвлөрүүлсэн үйлчилгээний хураамж

Орон нутгийн дансанд шинээр үүсгэн байгуулагдсан болон хуулийн этгээдийн бүртгэлийн өөрчлөлт, лавлагааны үйлчилгээний хураамж болох 18167500 /арван найман сая нэг зуун жаран долоон мянга таван зуу/-н төгрөг, улсын бүртгэлийн дансанд хуулбар, нэрийн баталгаажуулалтын үйлчилгээний хураамж 141000 /нэг зуун дөчин мянган/-н төгрөгийг төвлөрүүлэн ажилласан байна.

Үүнээс 152 иргэний үйлчилгээний хураамж болох 2090000 / хоёр сая ерэн хоёр мянга /-н төгрөгийг цахимаар тушаалгасан байна

Улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх ажил

2020.01.31-нд Аймгийн Далай ван телевизэд хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг хэрхэн бүртгүүлэх мөн төрийн бус байгууллагын тайлан ирүүлэлтийн талаар мэдээлэл өгөв.

2020.03.23-нд Аймгийн Далай ээж телевизийн “Хөх сувд” мэдээллийн хөтөлбөрт улсын бүртгэлийн зарим төрлийн үйлчилгээг хэрхэн цахимаар авах тухай мэдээлэл өгөв.

2020.02.03-нд Аймгийн ЛХА телевизийн “Мэдээллийн цаг” хөтөлбөрт хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг хэрхэн бүртгүүлэх мөн төрийн бус байгууллагын тайлангийн талаар мэдээлэл өгсөн.

2020.05.12-нд Аймгийн Далай ээж телевизийн “Хөх сувд хөтөлбөрт хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг хэрхэн бүртгүүлэх, улсын бүртгэлийн зарим төрлийн үйлчилгээг хэрхэн цахимаар авах тухай мэдээлэл өгөв.

2020.10.28-нд Түмний телевизэд Улсын бүртгэлийн 80 жилийн ойн арга хэмжээ угтсан ажил болон хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг хэрхэн бүртгүүлэх талаар мэдээлэл өгөв.

2020.12.02-нд Түмний телевизэд хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг цаасаар болон цахимаар хэрхэн бүртгүүлэх, улсын бүртгэлийн зарим төрлийн үйлчилгээг хэрхэн цахимаар авах тухай мэдээлэл өгч ажилласан.

Хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг иргэдэд ойртуулахын тулд утсаар зөвлөгөө мэдээллийг өгч, оноосон нэрийн хүсэлтийг утсаар авч шүүн хариу хүргүүлж, хуулийн этгээд шинээр байгуулах, нэмэлт өөрчлөлт бүртгүүлэхтэй холбоотой загвар маягтыг сумдын улсын бүртгэгчээр дамжуулан иргэдэд хүргүүлж хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг чирэгдэлгүй авах нөхцөл боломжоор ханган ажиллаж байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээний шинэлэг мэдээ мэдээллийг суртчилах чиглэлээр өөрийн байгууллагын Face book-н Faje хуудсанд хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой мэдээ мэдээлэл болон цаг үеийн мэдээллийг тухай бүр байршуулан нийтэд түгээн ажиллаж байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, холбогдох журмуудын шинэлэг зохицуулалтын талаарх мэдээлэл, Хуулийн этгээдийн бүртгэлийн газраас гаргасан дүрсжүүлсэн гарын авлага мэдээллийг байгууллагын байранд байрлах дэлгэцээр гаргаж иргэдэд мэдээлэл түгээж байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг олон нийтэд түгээх зорилгоор санал хүсэлтийн хайрцаг бүхий мэдээллийн самбарыг байгууллагын байрны үйлчилгээний зааланд байршуулан ажиллаж байна.

Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр үйлчилгээ авсан 187 иргэнд msg-ээр хариу мэдэгдэж, 2020 оны эхний 11 сарын байдлаар давхардсан тоогоор 543 орчим иргэдэд утсаар зөвөлгөө мэдээлэл өгч ажилласан байна.

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.3-т заасан нээлттэй мэдээллийг хэрхэн танилцах, хуулийн этгээдийн лавлагаа, хуулийн этгээдтэй эсэх талаарх лавлагааг хэрхэн цахимаар авах, мөн улсын бүртгэлийн үйлчилгээний тэмдэгтийн хураамжыг E-barimt, интернэт банкаар дамжуулан тушаах боломжтой тухай төрийн байгууллагад албан бичиг хүргүүлэв. / Хэлтсийн даргын 2020.05.15-ны 1/758 тоот албан бичиг / зурган файл хавсаргав.

Төлөвлөгөөт ажил

2018 оны 11 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын 2 дугаар зүйлд төрийн байгууллага албан газар улсын төсөвт үйлдвэрийн газрыг “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар улсын төсөвт үйлдвэрийн газар хэлбэрээр бүртгэх ажлыг хууль

хэрэгжиж эхэлсэнээс хойш 2 жилийн хугацаанд хийж гүйцэтгэх тухай заасны дагуу төрийн байгууллагуудад албан бичиг хүргүүлэн ажиллаж байна.

Мөн журманд боловсрол сургалт, хэвлэл мэдээллийн байгууллагаар 2018 оны 11 дүгээр сарын 01-ны өдрөөс өмнө улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэгдсэн хуулийн этгээдийг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасны дагуу компани, холбоо, сан хэлбэрээр бүртгэх ажлыг зохион байгуулж хуулийн этгээд үүсгэн байгуулагч нарт утсаар мэдэгдэн хуулийн хугацаанд хэлбэрийн өөрчлөлтөө бүртгүүлэх талаар мэдээлэл өгч ажиллаж байна.

Шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй 160 хуулийн этгээдийн судалгааг гаргаж excel файл дээр цахим сан үүсгэв.

2019 оны 7 дугаар сараас хойш аймгийн хэмжээнд хийгдсэн шилжилт хөдөлгөөний гурван дэвтрийн 931 иргэдийн мэдээллийг иргэний сантай тулган шалгаж тухайн шилжилт хөдөлгөөний 177 иргэний бүрдүүлбэр материалыг улсын бүртгэлийн ерөнхий газрын хяналтын газарт хүргүүлэхэд бэлдэн ойролцоогоор 1239 хуудас материалыг хавтас үүсгэн скайнардсан.

Аймгийн хэмжээнд бүртгэгдсэн төрийн бус байгууллагыг 23-н сумаар нь ялган excel файл үүсгэсэн.

Суманд үйл ажиллагаа явуулж байгаа 72 төрийн бус байгууллагын тайлан ирүүлэлт дээр хамтран ажиллах зорилгоор сумдын улсын бүртгэгч нарт албан бичиг, тайлан ирүүлэх загвар хүснэгт, мөн тухайн сумданд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагын мэдээллийг хүргүүлэн ажилласан.

Мөрөн суманд 194 үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагын үүсгэн байгуулагч нарын утасны дугаараар тайлангаа хуулийн хугацаанд ирүүлэх талаар зөвөлгөө өгч ажиллалаа.

Хөвсгөл аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн faje хуудас, Хөвсгөл аймгийн хэмжээний төрийн бус байгууллагын нэгдсэн face групп / Хөвсгөл ТББ /-д төрийн бус байгууллагын тайлан ирүүлэх тухай мэдээлэл, тайлангын загвар маягтыг тус тус байршуулан.

Төрийн бус байгууллагын үйл ажиллагааны тайлан ирүүлэх хуулийн хугацаанд 107 төрийн бус байгууллагын тайланг хүлээн авч нэгтгэн архивт хүлээлгэн өглөө.

Татварын ерөнхий хууль/ шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдөр батлагдсантай холбогдуулан 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн хуулийн этгээд нь тухайн хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдөрт багтаан хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлнэ” гэж заасны дагуу хууль хэрэгжүүлэх ажлын хүрээнд сумдын улсын бүртгэгч, татварын байцаагч нартай хамтран суманд үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдэд мэдээлэл

хүргүүлэв. / хэлтсийн даргын 2020.05.20-ны 1/757 тоот албан бичиг / зурган файл хавсаргав.

Аймгийн татварын хэлтэст хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг нөхөн бүртгүүлэхэд хамтран ажиллах тухай албан тоот хүргүүлэв. / хэлтсийн даргын 2020.05.20-ны 1/799 тоот албан бичиг /

Одоогийн байдлаар сумдын улсын бүртгэгч, татварын байцаагч нар хамтран суманд үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийн судалгааг гаргаж хуулийн этгээд эзэмшигч иргэдэд мэдээлэл хүргүүлэн ажиллаж байна.

2020 оны 11 сарын 25-ны байдлаар шинээр үүсгэн байгуулагдсан 139 хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч, нэмэлт өөрчлөлт бүртгэл хийгдсэн 652 хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг нөхөн бүртгэсэн байна.

Хуулийн этгээдийн мэдээлэлд өөрчлөлт оруулсан тохиолдолд улсын бүртгэлийн байгууллагад ажлын 15 хоногийн дотор бүртгүүлэхээр хуульд заасан боловч энэ хугацаанаас хоцрох тохиолдол нэлээдгүй гарч байгаа тул төрийн байгууллагуудад зөвлөмж хүргүүлэн ажиллаж байна.

Аймгийн Татварын хэлтэс, Тагнуулын ерөнхий газрын харьяа Хөвсгөл аймаг дахь хэлтэс, Статистикийн хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтэстэй хамтран ажиллаж шинээр бүртгэгдсэн болон татан буугдсан аж ахуй нэгжүүдийн бүртгэлийг сар, улирал тутам тулган баталгаажуулан ажиллаж байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн egs программаар ирүүлсэн 32 чиглэл зөвлөмж хариутай албан бичиг судалгааг тогтоосон хугацаанд хүргүүлэн ажилласан.

Улсын бүртгэлд бүртгэлтэй боловч холбогдох байгууллагад тайлан мэдээгээ хуулийн хугацаанд гаргаж өгдөггүй хуулийн этгээдийн жагсаалтыг гаргаж аймгийн таварын хэлтэс, төрийн сангийн хэлтэстээс судалгааг гаргуулан авч авч нэгтгэн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу холбогдох арга хэмжээг аван ажиллаж байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 6/10360 тоот албан бичиг, 2020 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 6/6646 тоот хууль хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай тус тус албан бичгүүдэд дурьдагдасны дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн хуулийн этгээдийн улсын бүртгэгчийн 2020 онд хийх ажлын төлөвлөөний 2 дугаар хэсэгт хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг нөхөн бүртгэх тухай тусгасан.

1. Аймгийн Далай ван телевизэд хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг хэрхэн бүртгүүлэх талаар мэдээлэл өгөв.
2. Аймгийн Далай ээж телевизийн “Хөх сувд” мэдээллийн хөтөлбөрт улсын бүртгэлийн зарим төрлийн үйлчилгээг хэрхэн цахимаар авах, хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг хэрхэн бүртгүүлэх тухай мэдээлэл өгөв.

3. Аймгийн ЛХА телевизийн “Мэдээллийн цаг” хөтөлбөрт хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг хэрхэн бүртгүүлэх талаар мэдээлэл өгөв.
4. Аймгийн Далай ээж телевизийн “Хөх сувд хөтөлбөрт хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг хэрхэн бүртгүүлэх, улсын бүртгэлийн зарим төрлийн үйлчилгээг хэрхэн цахимаар авах тухай мэдээлэл өгөв.
5. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, холбогдох журам, эцсийн өмчлөгчийг хэрхэн бүртгүүлэх талаарх мэдээлэл, Хуулийн этгээдийн бүртгэлийн газраас гаргасан дүрсжүүлсэн гарын авлага мэдээллийг байгууллагын байранд байрлах дэлгэцээр гаргаж иргэдэд мэдээлэл түгээж байна.
6. Байгууллагын гадна байрлах урсдаг самбараар хуулийн этгээдийн улсын бүртгэлийн эцсийн өмчлөгчийг нөхөн бүртгэх тухай богино хэмжээний мэдээ мэдээллийг түгээн ажиллаж байна.
7. Хууль хэрэгжүүлэх ажлын хүрээнд сумдын улсын бүртгэгч, татварын байцаагч нартай хамтран суманд үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдэд мэдээлэл хүргүүлэв. / хэлтсийн даргын 2020.05.20-ны 1/757 тоот албан бичиг / зурган файл хавсаргав.
8. Аймгийн татварын хэлтэст хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг нөхөн бүртгүүлэхэд хамтран ажиллах тухай албан тоот хүргүүлэв. / хэлтсийн даргын 2020.05.20-ны 1/799 тоот албан бичиг /
9. Хэлтсийн даргын 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 1/757 тоот албан бичгээр сумдын улсын бүртгэгч нарт эцсийн өмчлөгчийг хэрхэн бүртгүүлэх талаар чиглэл өгөв. Одоогийн байдлаар сумдын улсын бүртгэгч, татварын байцаагч нар хамтран суманд үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийн судалгааг гаргаж хуулийн этгээд эзэмшигч иргэдэд утсаар мэдээлэл хүргүүлэн ажиллаж байна.
10. Үл хөдлөх эд хөрөнгийн тасгийн улсын бүртгэгч нарт хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн талаар мэдээлэл өгч хамтран ажиллаж байна.
11. Мөрөн суманд бүртгэлтэй хуулийн этгээд эзэмшигч иргэдэд утсаар мэдээлэл өгөн ажиллаж байна. Одоогийн байдлаар хоршоо, нөхөрлөл, шашны байгууллага, сан, үйлдвэрчний эвлэлийн байгууллагыг үүсгэн байгуулагч нарт утсаар мэдээлэл өгөн ажилласан байна.
12. Сумдаас хамгийн олон хуулийн этгээдтэй сум болох Тариалан сумыг сонгон авч хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч хувьцаа эзэмшигч нартай утсаар холбогдон эцсийн өмчлөгчийн мэдээллээ хуулийн хугацаанд бүртгүүлэх тухай зөвлөмж өгч ажиллалаа. Энэ ажлын үр дүнд Тариалан сумын бүртгэгч дээр хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч нөхөн бүртгүүлэх хүсэлтээ 35 иргэн гаргаж материалаа ирүүлсэнийг татан авч бүртгэх ажил хийж байна.
13. Улсын бүртгэлд бүртгэлтэй хуулийн этгээдүүдийн тодорхой хувь нь холбогдох хуулийн дагуу харилцагч байгууллагад тайлан мэдээгээ тогтмол гаргаж өгдөггүй идэвхигүй үйл ажиллагаатай хуулийн этгээдийн судалгааг аймгийн Татварын хэлтэс болон Санхүү төрийн сангийн хэлтээс гаргуулан авч хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу

улсын бүртгэлээс хасуулах арга хэмжээ авахаар ажиллаж байна. / Хэлтсийн даргын 2020.09.01-ны 1/1217, 1/1218 тоот албан бичиг /

14. Мөрөн сумын хэмжээнд эцсийн өмчлөгч бүртгүүлэх шаардагатай 1097 хуулийн этгээдийн судалгааг гарган хэлтсийн бүх албан хаагчдын дэмжлэгтэйгээр эцсийн өмчлөгчөө хуулийн хугацаанд бүртгүүлэх талаар утсаар мэдэгдэн ажиллав.

15. 2020.10.28-нд, 2020.12.02-нд тус тус Түмний телевизэд Улсын бүртгэлийн 80 жилийн ойн арга хэмжээ угтсан ажил болон хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг цаасаар болон цахимаар хэрхэн бүртгүүлэх, улсын бүртгэлийн зарим төрлийн үйлчилгээг хэрхэн цахимаар авах тухай мэдээлэл өгөв.

Төрийн байгууллагын хамтын ажиллагаа

Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг нөхөн бүртгүүлэхэд хамтран ажиллахыг уриалж аймагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагад албан бичиг мэдээлэл хүргүүлэв.


Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.3-т хуульд заасны дагуу нээлттэй мэдээлэлтэй хэрхэн танилцах зэрэг зөвлөмжүүдийг хүргүүлэн ажиллав.

Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн бүртгэлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр Хөвсгөл аймгийн татварын хэлтэс, төрийн сан, арилжааны банкуудтай хамтран ажиллаж байна.

2016-2020 оны байдлаар шинээр үүсгэн байгуулагдсан татан буугдсан хуулийн этгээд




2016-2020 онд хүлээн авсан материал



2014-2020 Орон нутгийн болон улсын бүртгэлийн дансанд орсон үйлчилгээний хураамж



2015-2020 онд тамга тэмдэгний хяналтын дугаар авсан болон хураагдсан тамга тэмдэг



6. БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хөвсгөл аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн хяналтын улсын байцаагч Б.Мөнгөнзул нь 2020 оны хэлтсийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө боловсруулан хэлтсийн даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллалаа. 2020 оны хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө болон ажлын байрны тодорхойлолтонд заагдсан Улсын бүртгэл, түүнтэй холбоотой бусад үйл ажиллагаанд зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, илэрсэн зөрчлийг арилгуулах, улсын бүртгэлийн ажилтны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэнд хяналт тавих чиг үүргийн дагуу 2020 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Бодлого зорилтыг хангах чиглэлээр:

Тайлант хугацаанд хяналт, шалгалтын ажлыг хэрэгжүүлэхдээ Улсын бүртгэлийн ерөнхий хууль, иргэний бүртгэлийн тухай хууль, хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хууль, эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хууль тогтоомжоор улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэхээр заасан чиг үүргийн хүрээнд УБЕГазрын дарга болон хяналт шалгалтын газрын даргын төлөвлөгөөт ажлын хэрэгжилтийг ханган ажиллаа.

Мөн төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, байгууллагын үйлчилгээний стандарт, хөдөлмөрийн дотоод журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг

болгон ажилласан. Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд нийт 21543 бүртгэлд хяналт тавьж 881 зөрчлийг арилган ажилласан.

Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих, нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангаж ажиллах, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, цаг хугацааны хуваарь гаргаж Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/04 тоот “Ажлын хэсэг байгуулах” тушаалаар ажлын хэсгийг ахлан ажиллаж байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 25 дугаар зүйл. 25.1 дэх хэсэгт заасан хугацаанд иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг зогсоохтой холбогдуулан Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйл. Монгол Улсын Засгын газрын 2018 оны 332 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх, журам” –ын биелэлтэд хяналт тавьж ажиллав. Тус хэлтэсд бүртгэгдсэн 17898 иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сан болон иргэний улсын бүртгэлийн дэвтэрт бүртгэгдсэн эсэх, эотлох баримтын бүрдүүлбэр холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд нийцсэн эсэхийг хянаж шалгахад 150 иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлд зөрчил илэрснийг ХШГазрын 2020 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 06 тоот Хяналтын улсын байцаагчийн шаардлагын дагуу зохих арга хэмжээ авч, тогтоосон хугацаанд зөрчлийг арилган, биелэлтийг илтгэх хуудсаар хүргүүлэн ажилласан байна.

Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийн дэвтэрт 2017 оны 07 дугаар сарын 01-ны өдрөөс хойш бүртгэгдсэн бүртгэлийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд үнэн зөв, бүрэн бүртгэгдсэн эсэхийг хянах, нягтлан шалгах ажлыг гүйцэтгэсэн байна.

Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийн 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс 2020 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийг дуусталх хугацаанд бүртгэгдсэн 1558 бүртгэлийн нотлох баримт бүрдүүлбэр, бүртгэлийн дэвтэрт бүртгэгдсэн эсэх, ИУБ-22 маягт хэвлэгдсэн эсэх, мэдээллийн санд орсон эсэхийг нягтлан шалгаж ажиллалаа.

Хяналт шалгалтын газрын даргын 2020 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 8/409 албан бичгээр ирүүлсэн үүрэг, чиглэлийн дагуу Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 25 дугаар зүйл. 25.1 дэх хэсэгт заасан хугацаанд иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг зогсоосон тул өөрийн нэгжид хамаарах 23 сум 1 тосгоны шилжилт хөдөлгөөний бүртгэлийн дэвтэр, ИУБ-22 маягтын үлдэгдлийг тулган шалгаж, акт үйлдэн, лацдаж, хадгалах ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн тухай хуулийн 20 дугаар зүйл. 20.9 –д заасан сонгуулийн нэг хэсгээс нөгөө хэсэгт шилжих 1458 сонгогчийн

шилжүүлгийн нотлох баримтад хяналт тавьж хэвлэгдсэн лавлагаанд гарын үсэг зурж тэмдэг дарж баталгаажуулан ажиллав.

Сонгогчдын нэрийн жагсаалтын “Түр хасав” тэмдэглэгээ хийгдсэн шалтгаан арилж сэргээгдэх тохиолдолд холбогдох нотлох баримтыг хянаж сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулах тухай лавлагаанд гарын үсэг үурж, тэмдгээр баталгаажуулан ажилласан.

Баримт бичиггүй 2 иргэний хүчингүй болсон регистрийн дугаарыг сэргээж бичиг баримтжуулсан, регистрийн дугаар өөрчилж, дахин олгосон 8, бүртгэл хүчингүй болгосон 3, зөрчил арилгах 15, бүртгэл сэргээсэн, залруулга 1, регистрийн дугаар хүчингүй болгох 34, бүртгэлд засвар өөрчлөлт оруулах 6 зөрчлийг шийдвэрлэсэн байна.

Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдын хурлын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих, нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангаж ажиллах, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, цаг хугацааны хуваарь гаргаж Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/04 тоот “Ажлын хэсэг байгуулах” тушаалаар ажлын хэсгийг ахлан ажилласан.

Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.9 дэх хэсэгт “Улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 20.4-т заасны дагуу цахим хуудаст байршуулсан сонгогчдын нэрийн жагсаалтад дараах өөрчлөлтийг тусган уг жагсаалтыг цаасан болон цахим хэлбэрээр үйлдэж, цаасан хэлбэрээр үйлдсэн сонгогчдын нэрийн жагсаалтыг санал авах өдрөөс 25-аас доошгүй хоногийн өмнө улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтэсээр дамжуулан хэсгийн хороонд хүргүүлнэ” гэж заасны дагуу СНЖ-ыг хэвлэх явцад хяналт тавьж ажилласан байна. Галт, Шинэ идэр, Төмөрбулаг, Жаргалант сумдуудад СНЖ-ыг сонгуулийн хороонд хүлээлгэн өгсөн.

Нэгж дэх шилжилт хөдөлгөөний бүртгэл тус бүрийн нотлох баримтыг хянаж, хянасан тэмдэглэгээ хийж, хянахад илэрсэн зөрчлийг хуульд нийцүүлэн тухай бүр шийдвэрлэж, залруулах, хүчингүй болгох арга хэмжээг авч ажилласан.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020 оны 08 дугаар сарын 12-ны А/1257 тушаалаар Хяналт шалгалтын газраас тус хэлтсийн үйл ажиллагаанд төлөвлөнөөт шалгалтаар илэрсэн 11 зөрчлийг арилгуулан тайланг хүргүүлсэн.

2020 онд иргэний улсын бүртгэлийн үйл ажиллагаанд 21079 бүртгэлд хяналт шалгалт хийж 521 зөрчлийг илрүүлж хяналтын байцаагчийн 99 удаагийн дүгнэлтээр зөрчлийг арилгаж зөрчлийн тухай хуулиар 422 зөрчлийг шалган шийдвэрлэсэн.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр:

Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын дугаар А/289 тушаалаар батлагдсан “Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн заасныг тус тус үндэслэн 2020 оны хяналтын байцаагчийн хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан болон өдөр тутмын, түүвэрчилсэн хяналтаар эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр нийт 240 бүртгэлд хяналт тавьж ажиллан, Хяналтын байцаагчийн 19 удаагийн дүгнэлтээр эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн цахим сан дахь 130 зөрчлийг арилгасан байна. Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд эрхлэн хөтөлж байгаа эсэх, түүний хадгалалт хамгаалалт, найдвартай байдлыг ханган ажиллаж байгаа эсэхэд байнгын хяналт тавин ажиллаж байна.

Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр:

Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын дугаар А/289 тушаалаар батлагдсан “Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1.2, 6 дугаар зүйлийн заасныг тус тус үндэслэн 2019 оны хяналтын байцаагчийн хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан болон өдөр тутмын, түүвэрчилсэн хяналтаар хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр нийт 109 бүртгэлд хяналт тавьж, заавар зөвлөгөө өгч ажилласан байна.

Хуулийн этгээдийн архивын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд эрхлэн хөтөлж байгаа эсэх, түүний хадгалалт хамгаалалт, найдвартай байдлыг ханган ажиллаж байгаа эсэхэд байнгын хяналт тавин ажиллав.

Тайлант хугацаанд хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр хяналтын байцаагчийн 5 удаагийн дүгнэлтээр хуулийн этгээдийн 21 зөрчлийг арилгаж, 109 бүртгэлд хяналт тавьж ажилласан.

Хагас жилд хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг бүртгэх ажил 200 хүрэхгүй аж ахуй нэгж бүртгэгдсэн байсныг арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж ажилласны үр дүнд аймгийн хэмжээнд 2031 хуулийн этгээд, аж ахуйн нэгж бүртгүүлснээс өнөөдрийн байдлаар 813 хуулийн этгээдийн бүртгэлийн эцсийн өмчлөгч бүртгэгдсэн байна.

2020 онд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд нийт 109 бүртгэлд хяналт шалгалт хийж, хяналтын байцаагчийн 5 удаагийн дүгнэлтээр 21 зөрчлийг арилгасан үзүүлэлттэй байна.

Торгууль, шийтгэвэр:

2020 онд бүртгэлийн холбогдох хууль тогтоомж зөрчсөн 422 иргэн, хуулийн этгээдэд зөрчлийн хуулийн дагуу шийтгэл оногдуулж арга хэмжээ авч ажилласан байна.

Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс

Зөрчлийн тухай хуулийн дагуу 420 иргэнд 12.020.00,000 мянган төгрөгний, 2 хуулийн этгээдэд тус бүр 500.000 төгрөг нийт 13.020.000 төгрөгний шийтгэл ногдуулсан байна.

Тайлант хугацаанд улсын бүртгэлтэй холбоотой асуудлаар иргэдээс нийт 254 өргөдөл, гомдол хүлээн авч хугацаанд шийдвэрлэн зөрчлийг арилган ажилласан.

Иргэдээс ирүүлсэн өргөдлийг төрлөөр нь авч үзвэл:

- Иргэний бүртгэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар -99
- Эд хөрөнгийн бүртгэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар - 130
- Хуулийн этгээдийн бүртгэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар -21
- Бүртгэлийн хяналтын үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар -0
- Иргэний цахим үнэмлэх, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой асуудлаар -422


Бүртгэлийн хяналтын үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар гаргасан 254 өргөдөл гомдол, хүсэлтийн дагуу хяналтын байцаагчийн 123 удаагийн дүгнэлтээр 250 өргөдлийг шийдвэрлэсэн бөгөөд 4 өргөдлийг нь шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлэхээр албан бичиг хүргүүлэн ажилласан .

Хяналт шалгалтын ажлын статистик тоон мэдээг сарын бүрийн 25-наар тасалбар болгон УБЕГ-ын Хяналт шалгалтын газарт хүргүүлэн ажиллаж байна.


Сургалтанд хамрагдсан байдал:


2020 оны 04 сард Хяналт шалгалтын газраас зохион байгуулсан онлайн, 2020 оны 05 дугаар сард “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” цахим сургалтанд тус тус хамрагдсан. УБЕГ-ын даргын тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу Хяналт шалгалтын газрын дарга Б.Ганзоригоор ахлуулсан ажлын хэсэг 2020.08.23-25-ны өдрүүдэд тус хэлтсийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн. Уг шалгалтын багтай хамтран ажиллаж, сургалт зөвлөгөө авсан ба илрүүлсэн зөрчлийг засч залруулан зөрчлийг арилгасан тухай илтгэх хуудсыг УБЕГ-ын Хяналт шалгалтын газарт хүргүүлэн ажиллалаа.


Хяналтын улсын байцаагчийн гаргасан дүгнэлтийг сүүлийн 3 жилээр харьцуулбал:



Хяналтын улсын байцаагчийн ноогдуулсан торгуулийн мөнгөн дүнг сүүлийн 3 жилээр харьцуулбал







7. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагааны урсгал төсөв 661186.3 мян/төгрөг батлагдсанаас 2020 оны 12 сарын 10-ны байдлаар 667972.8 мян төгрөгийн санхүүжилт хийгдэж албан хаагчдын цалингийн зардал хүрэлцэхгүй байгааг шийдвэрлүүлэхээр УБЕГазарт санал хүргүүлж тухайн жилийн төсөвт 6786.5 мян.төгрөгийн санхүүжилтыг цалингийн зардал дээр нэмж хуваарилуулан цалин болон бусад зардалтай холбоотой ямар нэгэн өглөггүй ажиллаж байна.

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу зарцуулж, байгууллагын өдөр тутмын санхүүгийн үйл ажиллагааг тасралтгүй тогтмол явуулж, нягтлан бодох бүртгэлийн болон анхан шатны бүртгэл хөтлөлтийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийж гүйцэтгэсэн.

Мөн байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос 2020 оны 12 сарын 10-ны байдлаар 164843.1 мян/төгрөгийн орлогыг оруулж улсын төсөвт төвлөрүүлж, 2020 оны 11 сарын 30-ны байдлаар улсын тэмдэгтийн хураамж 49584,0 мян/төгрөгийг сумын төсөвт, 111696,4 мян/төгрөгийн үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсан орлогыг аймгийн төсөвт оруулсан байна.

2020 оны МУ-н УИХ-н сонгуулиар 128506.6 мян.төгрөгийн санхүүжилт, Аймаг сум дүүргийн ИТХ-н сонгуулиар 92128.5 мян.төгрөгийн санхүүжилт хийгдэн, батлагдсан хуваарийн дагуу зарцуулан аймгийн аудитын газраар аудит хийлгэн ямар нэгэн акт зөрчилгүй дүгнүүлсэн.

Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс

Няравын үнэт цаасны тооллогыг улирал бүр, эргэлтийн хөрөнгийн тооллогыг эхний хагас жилд 1 удаа явууллаа. “Санхүүгийн ил тод байдлын самбар”-т шаардлагатай мэдээллийг үнэн зөв ил тод байдлаар хэлтсийн удирдлага ард иргэдэд мэдээлэх ажлыг тогтмол хийж гүйцэтгэдэг.


Сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, орлогын мэдээг сар бүрийн 2-ны дотор УБЕГ-ын санхүүгийн хэлтэст гарган өгч хэвшсэн. Мөн сумдын болон төвийн улсын бүртгэгчдийн зарцуулсан үнэт цаасны тайланг сар бүрийн 25-наар тасалбар болгон шалгаж тухайн сард шаардах хуудсаар авсан үнэт цаасны хатуу дугаар, няравын агуулахын бүртгэлийн дэвтэртэй нэг бүрчлэн тулгаж баталгаажуулж УБЕГазрын санхүүд хүргүүлэн нэгтгүүлж байна.

Хэлтсийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Аймгийн Төрийн аудитын газар шалгалт шилжилгээ хийж 2020 оны 2 сарын 20-ны өдөр хүлээлгэн өгч “ИТГЭМЖЛЭЛ” авч ажилласан байна.

Засгийн газрын 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дугаар 384 тогтоол, Шилэн дансны тухай хууль 3.1.4 3.2.4 –т заасны дагуу сар бүрийн мөнгөн гүйлгээ түүнтэй холбоотой ажил гүйлгээг сар бүрийн 8-ны дотор “Шилэн дансны систем” болон Санхүүгийн ил тод байдлын самбарт байршуулж хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2020 оны 11 сарын байдлаар нийт 133 төрлийн мэдээллийг байршуулахаас хуулийн хугацаанд 133 мэдээллийг байршуулаад байна.

Тус хэлтэс нь 2019 оны санхүүгийн үйл ажиллагаагаар аймгийн “Санхүүгийн зөрчилгүй” байгууллагаар шалгарч төрийн байгууллагын хэмжээнд 2 дугаар байр эзлэн 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдөр Аймгийн засаг даргаас шагналаа гардан авсан.






8. АРХИВ, АЛБАН БИЧИГ ХӨТЛӨЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Байгууллагын ирсэн, явсан бичгийн бүртгэл хөтөлж, хариутай бичгийн шийдвэрлэлтэнд хяналт тавьж ажиллалаа. Тус хэлтэс нь 2020 оны жилийн эцсийн байдлаар 1600 албан бичгийг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажласан бөгөөд 1200 албан бичгийг хүлээн авсан байна. Хүлээн авсан 1200 албан бичгээс 650 нь хариутай албан бичиг байсан ба холбогдох хариуг цаг хугацаанд нь шийдвэрлэж хүргүүлсэн байна. Тайлант хугацаанд Хэлтсийн даргын 26 тушаалыг бүртгэж ажилласнаас байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой А тушаал 19, хүний нөөцтэй холбоотой Б тушаал 7-г тус тус гарган хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан. Мөн тайлант хугацаанд улсын бүртгэлтэй холбоотой асуудлаар иргэдээс нийт 95 өргөдөл, гомдол ирсэн бөгөөд 93 өргөдөл, гомдлыг холбогдох эрх бүхий албан тушаалтанд нь хуваарилан, шийдвэрлүүлж, 2 өргөдөл гомдлын шийдэвэрлэх хугацаа болоогүй хүлээгдэж байна. ABLE программд нийт дотоод албан бичиг 71 ирсэн ба 332 албан бичиг явуулсан байна. Khuvsgul@burtgel.gov.mn хаягаар 1415 албан бичиг, Орон нутгийн UBurtgel@khs.gov.mn хаягаар 139 албан бичиг тус тус ирсэн байна.

Хэлтсийн албан бичгийн хагас жилийн эргэлтийг сүүлийн 3 жилээр харьцуулбал:

Он	Ирсэн бичиг			Явсан бичиг	Хэлтсийн даргын тушаал			Өргөдөл, гомдол
	Хариутай	Хариугүй	Нийт		А тушаал	Б тушаал	Нийт	
2018 он	679	438	1117	1390	13	23	36	102
2019 он	483	373	418	1393	21	14	35	95
2020 он	650	1200	1850	1600	19	7	26	95



Иргэдээс ирүүлсэн өргөдлийг төрлөөр нь авч үзвэл:

- Иргэний бүртгэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар – 28
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар - 4
- Бүртгэлийн хяналтын үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар – 44
- Албан хаагчтай холбоотой гомдол – 2
- Албан хаагчийн нийгмийн асуудал болон хүний нөөцтэй холбоотой асуудлаар – 16
- Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар – 1



Мөн байгууллагын архивын хүрээнд ХАСХОМ-ын баримтыг байгууллагын архивын ажлын үндсэн зааврыг баримтлан хуудас нэг бүрээр нягтлан шалгалт хийж, оноор ялган, хуудсыг дугаарлаж, баримт ашиглалтын хуудас, дотоод товъёог, баталгааны хуудас хавсарган стандартын дагуу үдэж хавтаслаж цэгцэлж, ХАСХОМ-ын цаасан баримт, баталгааны маягт нь байгууллагын үйл ажиллагаанд үүссэн удирдлагын нийтлэг баримт бичгийн хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалтын 321 дугаарт “Боловсон хүчний хувийн баримт бичиг/нийгмийн даатгалын дэвтэр, аттестат, гэрчилгээ, диплом, үнэмлэх болон бусад/” гэсэн баримт бичгийн төрөлд хамаарагдаж тухайн боловсон хүчин нэхэж авах хүртэл байгууллагын архивт 70 жил хадгалагдах баримт юм.

Нийтдээ 2008-2020 оны 18 хадгаламжийн нэгж 2261 хуудас баримтад иж бүрэн нягтлан шалгалт, техник боловсруулалт хийж байгууллагын архивт жагсаалтаар хүлээлгэн өгсөн.

8. ХЭЛТСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ, ТОД НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ

- Мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор <https://www.facebook.com/khuvsgul.burtgel/?ref=bookmarks> фейсбүүк хаягийг 2015 оноос хойш ажиллуулж байгаа бөгөөд иргэдэд цаг үеийн мэдээ, мэдээллийг түргэн шуурхай хүргэн, 2020 онд иргэдээс ирүүлсэн нийт 127 чатанд хариу өгч асуудлыг шийдвэрлэн ажилласан.
- Иргэд бүртгэл хийлгэхэд шаардлагатай мэдээллийг цогцоор агуулсан “Бүртгэлийн Хөтөч” хавтсыг бэлтгэн үйлчилгээний зааланд байрлуулснаар иргэд үйлчилгээгээ илүү түргэн шуурхай авах боломж бүрдэж байна.
- Эд хөрөнгө эрхийн улсын бүртгэлийн тасгаас иргэдэд үйлчилдэг үйлчилгээний зааланд брошур, 3 төрлийн бүртгэлийн эвхэгддэг самбарын эхийг бэлтгэн байршуулж сумд руу хувилан хүргүүлэх ажлыг хийж хэрэгжүүлсэн.
- Иргэдээ сонсох утас 70388618 утсыг хэлтсийн хэмжээнд ажиллуулан иргэдийн асуусан бүх төрлийн мэдээ мэдээлэлд **188** удаагийн хариу өгч, өргөдөл гомдлыг хүлээн авч ажиллаж байна.
- Иргэдийн хэвлэгдэн ирсэн цахим үнэмлэх, гадаад паспорт, үл хөдлөх эд хөрөнгө болон газрын гэрчилгээний мэдээллийг 91108618 дугаарын утсаар мессеж илгээн иргэдийн цаг завьг хэмнэн ажиллаж байна. Тайлант хугацаанд нийт **1078** иргэнд холбогдох мэдээллийг мессеж үйлчилгээгээр хүргүүлэн ажилласан байна.
- Өглөөний дасгал, ажлын байрны дасгалыг хийж хэвших, өдөр бүрийн төрийн албан хаагчийн тангарагийг уншиж хэвшсэн байна
- Иргэд улсын бүртгэлийн хэлтсийн, лавлах утсаар ямар лавлагаа, үйлчилгээг асууж тодруулж мэдээлэл авдаг талаар болон бүртгэлийн үндсэн үйл ажиллагааны талаар телевизийн нэвтрүүлэгт хэлтсийн Хуулийн этгээдийн улсын бүртгэгч Д.Насанбуян оролцож Шинэ коронавирусээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд хэрэглэгчдэд утсаар мэдээлэл авч, онлайнаар үйлчилгээний хураамжаа төлөх буюу Ebarimt ашиглан төлбөр төлөх гэх мэт асуудлаар Хөвсгөл ард түмний телевизэд 7 мэдээлэл өгсөн.
- “Хариуцлагатай хэрэглэгч” сэдвийн хүрээнд хэлтсийн мэдээлэл технологийн ажилтан Э.Нарантуяа, гэрээт ажилтан О.Болдсайхан нар бүртгэлийн үйлчилгээтэй холбоотой мэдээлэл болон цахимаар хэрхэн бүртгэлийн үйлчилгээ авах талаар богино хэмжээний шторк бэлтгэж 3 дугаар сарын 13-наас эхлэн хэлтсийн цахим хуудсаар болон үйлчилгээний заалны телевизээр дамжуулан өдөр бүр иргэдэд хүргэн ажиллаж байна.

- Улсын бүртгэлийн байгууллагаар үйлчлүүлж буй иргэдээс 3 хоногийн хугацаанд судалгаа авч 3 дугаар сарын 18-ны өдөр Улсын бүртгэгч Д.Чимэдцогзол, ахлах нягтлан бодогч Б.Мөнхдэлгэр, Улсын бүртгэгч Б.Энхбаатар нар дүнг нэгтгэсэн. Нийт 34 иргэнээс судалгаа авсанаас 17 иргэн Эд хөрөнгө эрхийн улсын бүртгэлийн тасгаас, 11 иргэн Иргэний улсын бүртгэлийн тасгаас, 6 иргэн Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тасгаас тус тус бүртгэлийн үйлчилгээ авчээ. Үйлчилж буй албан хаагчийн харилцаа хандлагын тухай асуулгад 33 иргэн эерэг санал өгч 96.6% тай үнэлэгдсэн. Асуудлыг тань бүрэн шийдэж чадсан эсэх асуулгад 34 иргэн эерэг санал өгснөөр 100%-тай үнэлэгдэж, хүнд суртал чирэгдэл байсан уу гэх асуулгад 33 иргэн эерэг санал өгч мөн 96.6%-тай үнэлэгдсэн.
- Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор 3 дугаар сарын 13, 16-ны өдрүүдэд Улсын бүртгэлийн хэлтсээс үйлчилгээ авч буй иргэдэд амны хаалт 50 ширхэгийг тарааж, витаминжуулалтын арга хэмжээ авах ажлыг Хуулийн этгээдийн улсын бүртгэгч Д.Насанбуян, Архивч Д.Пүрэвсүрэн нар хэрэгжүүлсэн.
- Улсын бүртгэгч Б.Мөнхзул, Ч.Ганчимэг нар шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх заавар, зөвлөмжийг бэлтгэж үйлчилгээ авч буй иргэдэд танилцуулж, байгууллагын самбар болон үйлчилгээний цонхны дэргэд байрлуулж ажилласан.
- 2020.01.31-нд Аймгийн Далай ван телевизэд хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг хэрхэн бүртгүүлэх мөн төрийн бус байгууллагын тайлан ирүүлэлтийн талаар Хуулийн этгээдийн улсын бүртгэгч Д.Насанбуян мэдээлэл өгсөн.
- 2020.03.23-нд Аймгийн Далай ээж телевизийн “Хөх сувд” мэдээллийн хөтөлбөрт улсын бүртгэлийн зарим төрлийн үйлчилгээг хэрхэн цахимаар авах тухай мэдээлэл өгсөн.
- 2020.02.03-нд Аймгийн ЛХА телевизийн “Мэдээллийн цаг” хөтөлбөрт хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг хэрхэн бүртгүүлэх мөн төрийн бус байгууллагын тайлангийн талаар мэдээлэл өгөв.
- 2020.05.12-нд Аймгийн Далай ээж телевизийн “Хөх сувд хөтөлбөрт хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг хэрхэн бүртгүүлэх, улсын бүртгэлийн зарим төрлийн үйлчилгээг хэрхэн цахимаар авах тухай мэдээлэл өгөв.
- Аймгийн засаг даргын 2020 онын 02 сарын 20 ны өдрийн 3/473 албан даалгаврын дагуу хөвсгөл аймгийн хэмжээнд “Хүүхэд- Итгэлийн харц” аян зохион байгуулж энэхүү аяны хүрээнд хийгдсэн ажлын тайланг долоо хоног бүрийн баасан гариг бүр хийсэн ажлаа тайлагнаж ажилласан.

Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс

- Хөвсгөл аймгийн 24 сумын улсын бүртгэгчид 2020 онд 16 нас хүрч иргэний үнэмлэх авах, 25 ба 45 насны сунгалт хийлгэх иргэдийн судлагааг гаргаж багийн засаг дарга нартай хамтран хуулийн хугацаанд бүртгэлд хамруулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.
- Коронавирусын халдварын эрсдэл өндөр, тархалт эрс нэмэгдэж байгаатай холбогдуулан өндөржүүлсэн бэлэн байдалд шилжин ажиллаж хариуцлагатай жижүүрийг хувиар гарган Орон тооны бус штаб, мэргэжлийн анги шинэчлэн томилох тухай” Хэлтсийн даргын 2020 оны 02 сарын 14-ны өдрийн А/8 тушаалыг мөрдөн ажилласан байна. Мөн тусгай горимд шилжин ажиллах тухай УБЕГ-ын даргын 2020 оны 03 сарын 13-ны өдрийн А/259 тушаалыг тогтоосон хугацаанд мөрдөн ажилласан.
- Эд хөрөнгийн эрхийн бүртгэлтэй холбоотой мэдээ мэдээлэл, шинэчлэн болон өөрчлөгдөн гарсан хууль тогтоомж, хурам чиглэлийн дагуу болон цахимжилтын ажлын явц, Ebarimt-ийн ач холбогдол үр дүн зэргийг цаг тухай бүрт нь мэдээлж ажилласан.
- 2020 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр Хөвсгөл аймаг дахь ШШГГ, аймгийн Иргэний хэргийн анхан шатны шүүх, УБХэлтсийн хооронд зохион байгуулсан хэлэлцүүлэгт оролцон мэдээлэл хийж, уг хэлэлцүүлгээр тулгамдаж буй асуудал, шүүхийн шийдвэрийн шинэчилэгдсэн хуулийн хүрээнд хуулийг нэг мөр ойлгох, хуулийн хяналтын болон төрийн захиргааны байгууллагын хоорондын уялдаа холбоог сайжруулах чиглэлээр харилцан тохиролцон хамтран ажиллаж байна.
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд ойртуулахын тулд утсаар зөвлөгөө мэдээллийг өгч, оноосон нэрийн хүсэлтийг утсаар авч шүүн хариу хүргүүлж, хуулийн этгээд шинээр байгуулах, нэмэлт өөрчлөлт бүртгүүлэхтэй холбоотой загвар маягтыг сумдын улсын бүртгэгчээр дамжуулан иргэдэд хүргүүлж хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг чирэгдэлгүй авах нөхцөл боломжоор ханган ажиллаж байна.
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг олон нийтэд түгээх зорилгоор санал хүсэлтийн хайрцаг бүхий мэдээллийн самбарыг байгууллагын байрны үйлчилгээний зааланд байршуулан ажиллаж байна.
- Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр үйлчилгээ авсан 187 иргэнд мессежээр хариу мэдэгдэж, 2020 онд давхардсан тоогоор 543 орчим иргэдэд утсаар зөвөлгөө мэдээлэл өгч ажилласан.
- Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.3-т заасан нээлттэй мэдээллийг хэрхэн танилцах, хуулийн этгээдийн лавлагаа, хуулийн этгээдтэй эсэх талаарх лавлагааг хэрхэн цахимаар авах, мөн улсын бүртгэлийн үйлчилгээний тэмдэгтийн хураамжийг Ebarimt, интернэт банкаар дамжуулан тушаах боломжтой тухай төрийн байгууллагад албан бичиг хүргүүлсэн. / Хэлтсийн даргын 2020.05.15-ны 1/758 тоот албан бичиг/

- Хэлтсийн гадна талбайн тохижилтын ажлыг хийж гүйцэтгэн, хэлтсийн урд талбайн молны хашаа хайсыг шинэчлэн, бүх албан хаагчдыг хамруулан их цэвэрлэгээг хийж ажиллалаа.
- Шинэ коронавирусын халдварын үед хэлтсийн үйлчилгээний зааланд байрлах зурагт болон хэлтсийн цахим хуудсаар дамжуулан богино хэмжээний зөвлөмжүүдийг иргэдэд хүргэн ажиллахаас гадна хэлтсийн бүх албан хаагчид өөрсдийн цахим хуудсаар дамжуулан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх заавар зөвлөмжийг иргэдэд түгээн ажиллаж байна. Мөн “МАСКАА ЗҮҮЕ” аянд хэлтсийн бүх албан хаагчид нэгдэж, 30 секундын бичлэг бэлтгэн, бусад аймгийн Улсын бүртгэлийн хэлтсүүд болон аймгийн хэмжээн дэх төрийн байгууллагуудыг уриалан ажилласан.
- Хэлтсийн бага үнэтэй түргэн элэгдэх бараа материалын зардлаас 242.000 төгрөгний үнэ бүхий спирт, санитал, 1 удаагийн бээлий, цэвэрлэгээний бодис, бусад материалыг худалдан авч, иргэдэд үйлчилгээ үзүүлж буй цонхнууд болон 00-н өрөөнд гар ариутгагч саниталыг байршуулж, хэлтсийн албан хаагчдын болон иргэдийг гар халдваргүйжүүлэх нөхцлөөр бүрэн ханган ажиллаж байна.
- Хэлтсийн зүгээс 180.000 төгрөгний үнэ бүхий автомат халуун хэмжигчийг худалдан авч нийт албан хаагчдын болон үйлчлүүлж буй иргэдийн биеийн халууныг тогтмол хэмжин, тэмдэглэлийг өдөр бүрээр хөтлөн ажиллаж байна. Мөн хэлтсийн эргэлтийн эмийн сангийн эм, бусад зүйлсийг шинэчлэсэн. Тус аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг “Мөрөндөө сайхан амьдарья” төрийн бус байгууллагаас хэлтсийн нийт албан хаагчдад 100 ширхэг амны хаалт хандивласныг хүлээн авч, албан хаагчдадаа тараан өглөө.
- Хэлтсийн бүх өрөөнд агаар сэлгэлтийг тогтмол хийж, өдөр бүр чийгтэй цэвэрлэгээг хийхээс гадна хаалганы бариул, үйлчилгээний заалны шил, тавцанг 2 цаг тутамд зориулалтын бэлдмэлээр ариутгаж хэвшсэн байна.
- Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаал, шийдвэр болон эрүүл мэндийн байгууллага, улс, аймгийн онцгой комиссын шийдвэрийг тухай бүрт нь албан хаагчдад танилцуулан, УБЕГ-ын цахим хуудсанд байршуулсан шинэ коронавирусаас урьдчилан сэргийлэх заавар, зөвлөмж, шторкыг бүх албан хаагчид иргэдэд түгээн ажиллаж байгаагаас гадна, хэлтсийн гадна дотор хаалга, үйлчилгээний заалны цонх, хаалга бүрт зөвлөмжийг байршуулсан. Мөн хэлтсийн албан хаагчдыг хариуцлагатай жижүүрээр ажиллах хуваарийг 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдөр хэлтсийн даргаар батлуулан тухай бүрт тэмдэглэлийг хөтлөн ажилласан.

- Хэлтсийн нийт албан хаагчид өөрийн ажлын байрны халдваргүйжүүлэлт, цэвэрлэгээг тогтмол хийж хэвшсэн бөгөөд, Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 01/406 тоот "Цэвэрлэгээ, ариутгал хийх" тухай албан бичгийн дагуу 2020 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр тус хэлтэс нь орчны цэвэрлэгээг хийж, тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагатай хамтран үйлчилгээний зааланд 2 удаагийн ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж ажиллалаа.
- Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн хүрээнд сонгон авсан нэг бүтэн өнчин хүүхдэд бэлгийг гардуулан өгч, хагас жилийн байдлаар албан хаагчдын цуглуулсан 210.000 төгрөгийг хадгаламжинд нь хийж, дэвтэрт нь бичилт хийг ажилласан.
- Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2020 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн А/11 тоот тушаалаар Шинэ короновирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах зорилгоор 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийг дуустал 0-5 хүртлэх насны хүүхэдтэй эх /ганц бие эцэг/-д өдөрт 1 цагийн цалинтай чөлөөг олгож ажиллах тухай тушаал гарсан.
- Байгууллагын эцэг эхийн зөвлөл нь Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас ирүүлсэн зөвлөмж чиглэлийг хэрэгжүүлэн нийт албан хаагчдыг Хүүхэд хамгааллын "Ёс зүйн дүрэм"-тэй танилцуулж, эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаанд үнэлгээ хийх аргачлалын хүрээнд нийт хамт олноор үнэлүүлж 99.6% үнэлгээ авсан байна.
- Бага насны хүүхэдтэй эцэг эхэд хүүхдээ сургууль, цэцэрлэгт хүргэж өгөх авах, эргүүлд гарах, эцэг эхийн хуралд очих зэрэг цагийг зохицуулан, тухайн албан хаагчийн ажлыг түр орлон гүйцэтгэх албан тушаалтныг томилон төрийн албыг иргэдэд тасралтгүй хүргэж байна.
- Хөвсгөл аймгийн цагдаагийн газартай хамтран 2020 оны 3 дугаар сарын 11-ны өдөр онцгой дэглэм тогтоосон хугацаанд хамтран ажиллах, мөн цаашид бүртгэлийн тогтолцоо, шинэ эрүүгийн хууль, лавлагаа мэдээлэл солилцох журам зэргээр хэлэлцүүлэг зохион байгуулж төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх байгууллага хоорондын хамтын ажиллагааг сайжруулах зорилго тавин тодорхой үр дүнд хүрч ажилласан байна.
- Нийт албан хаагчдын хүүхдүүд хичээл сургуульдаа хэрхэн оролцож байгааг хянах эцэг эхчүүд чөлөөт цагаараа хүүхэдтэйгээ хэрхэн өнгөрүүлж байгаа талаар, эцэг эхийн зөвлөл байнгын хяналт тавин ажиллаж байна. Байгууллагын эцэг эхийн зөвлөл нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхдийг хамгаалах, хүүхэд гэр бүлийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр албан хаагчдад аймгийн Прокурорын байгууллагаас мэргэжлийн албан хаагчаар хичээл заалган харилцан ярилцаж санал бодлоо солилцлоо.
- Аймгийн Нэгдсэн эмнэлэгийн Дотрын тасагт хэвтэн эмчлүүлж байгаа Шинэ-Идэр сумын иргэн Улсын бүртгэлийн хэлтэст ажиллаж байсан, одоо Шинэ-Идэр сумын ЗДТГ-т ажиллаж байгаа иргэн Л.Намнандоржид эмчилгээнд нь

- зориулж дэмжлэг үзүүлэх зорилгоор албан хаагчдаас 100.000 төгрөг хандивласан
- “Эрүүл нийгмийн харилцаанд хариуцлагатай эцэг, эх байцгаая” амлалт, хариуцлагыг авч албан хаагчид “Төрийн албан хаагчийн тангараг”-ын дагуу иргэний үүргээ ухамсарлаж ажлын байранд болон үр хүүхдийнхээ дэргэд, архи согтууруулах ундаа хэрэглэхгүй байх амлалтыг долоо хоног бүр албан хаагчдаа сануулж аянд нэгдэж гарын үсэг зурж баталгаажуулсан.
 - Иргэний улсын бүртгэлийн тасгийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу ХХҮГазрын мэргэжилтэн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургагч багш М.Батчимэгтэй хамтран хэлтсийн нийт ажилтан, албан хаагчидад “Оффисийн аюулгүй ажиллагаа”, “Хөдөлмөрийн бүтээмжийн 5С зарчим ” сэдвээр сургалт зохион байгуулсан байна.
 - Монгол Улсын Их Хурлын болон Аймаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд Улсын бүртгэлийн байгууллагаас итгэмжлэгдсэн ажилтнаар ажиллах албан хаагчдын Эрх зүйн сургалтыг цахим хэлбэрээр тус тус амжилттай зохион байгуулсан.
 - Монгол Улсын Их Хурлын болон Аймаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн СНЖ-ийг хэвлэн сумын сонгуулийн хороонд тогтоосон хугацаанд тус тус амжилттай хүргүүлсэн.
 - Монгол Улсын Их Хурлын болон Аймаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн итгэмжлэгдсэн ажилтнаар ажиллах албан хаагчдад “Ирц бүртгэлийн програм”-ын сургалтыг амжилттай зохион байгуулж, тоног төхөөрөмж, СНЖ-ийг сумын сонгуулийн хороонд тогтоосон хугацаанд хүлээлгэн өгч ажилласан байна.
 - Монгол Улсын Их Хурлын болон Аймаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийг орон нутагтаа амжилттай зохион байгууллаа.
 - УБЕГ-аас ирүүлсэн “Орон нутаг дахь цахим хуудсын нэгдсэн платормд оруулах бодлого”-ын дагуу Хөвсгөл аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн албан ёсны Вэб сайт хөгжүүлж ажиллуулан шинэ мэдээ, мэдээллийг тухай бүр шинэчлэн иргэдэд хүргэн ажиллаж байна.
 - Улсын бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний 80 жилийн ойг угтан 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр Рашаант сумын Засаг даргын тамгын газартай хамтран “Нээлттэй хаалганы өдөр” зохион байгуулж иргэдэд иргэний улсын бүртгэл, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэн иргэдээс санал, хүсэлт, өргөдөл, гомдол хүлээн авч, гарын авлага тарааж нийт 130 гаруй иргэнд зөвөлгөө мэдээлэл өгч иргэнд төрийн үйлчилгээг шуурхай хүргэн ажилласан байна.

9. СУРГАЛТ, СЕМИНАР БОЛОВСОН ХҮЧНИЙГ БЭХЖҮҮЛЭХ

- Улсын бүртгэлийн ерөнхий газраас 2020 онд зохион байгуулсан 16 удаагийн онлайн сургалтанд хэлтсийн албан хаагчдыг чиглэл тус бүрээр хамруулсан.
- 2020 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр УБЕГ-аас зохион байгуулсан “Архив, албан хэрэг хөтлөлт”-ийн онлайн сургалтанд тус хэлтсийн бичиг хэргийн ажилтан Э.Ариунаа хамрагдаж able программ болон архив албан хэрэг хөтлөлтийн талаарх мэдлэгээ дээшлүүлсэн.
- 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдөр МУИС-ийн Иргэний эрх зүйн магистр Л.Өлзийтогтохын “Ёс зүй- Хууль” сургалтанд хэлтсийн бүх албан хаагчид хамрагдсан.
 - 2020 оны 5 дугаар сарын 04-ний өдөр сургагч багш Д.Батчимэгийн “Хөдөлмөрийн аюулгүй байдлын” сургалтанд бүх албан хаагчид хамрагдсан.
- 2020 оны 5 дугаар сарын 06-ны өдөр Хөвсгөл аймгийн Прокурорын газрын Хяналтын прокурор Ч.Батзориг тус хэлтсийн албан хаагчид болон сумдын нийт улсын бүртгэгч нарт зориулан “Бага насны хүүхдийн хамгаалал” сэдэвт сургалт зохион байгуулсан.
- Тус хэлтсийн төрийн жинхэнэ албан хаагчид 2020 оны 02 дугаар 07-ны өдөр Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах мэргэжилтэн Ш.Уртнасангийн зохион байгуулсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, тайлагнах арга зүй, анхаарах асуудлууд” сэдэвт сургалтанд хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүлсэн бөгөөд сургалтын дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөөг гаргасан.
- Хэлтсийн Ес зүйн хорооноос 2020.03.03-ны өдөр зохион байгуулсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын ёс зүйн дүрэм”, “Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандарт”-ыг хэрхэн мөрдөн ажиллах тухай сургалтанд хамрагдаж сорилын шалгалт өгсөн.
- 2020.03.23-ны өдөр Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас зохион байгуулсан цахим сургалтанд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн албан хаагчид бүрэн хамрагдсан.
- Тайлан хугацаанд Хөвсгөл аймгийн цагдаагийн газартай хамтран 2020 оны 3 дугаар сарын 11-ны өдөр онцгой дэглэм тогтоосон хугацаанд хамтран ажиллах, мөн цаашид бүртгэлийн тогтолцоо, шинэ эрүүгийн хууль, лавлагаа мэдээлэл солилцох журам зэргээр хэлэлцүүлэг зохион байгуулж төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх байгууллага хоорондын хамтын ажиллагааг сайжруулах зорилго тавин тодорхой үр дүнд хүрч ажилласан.
- УБЕГ-ийн Тамгын газраас зохион байгуулсан удирдах ажилтны зөвлөгөөнд 2020-ны 4 дүгээр сарын 16-ны өдөр чиглэл тус бүрээр хамрагдсан.

- 2020.01.04-нд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас хуулийн этгээдийн улсын бүртгэгч нарт зориулсан онлайн сургалт. Сургалтын сэдэв “Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч бүртгэх” тухай сургалтанд хамрагдсан.
- 2020.08.27-нд Улсын бүртгэлийн Хяналтын газраас хяналтын улсын байцаагч Ж. Чиймаагийн “Улсын бүртгэлийн хууль тогтоомжын биелэлтэнд тавих хяналт шалгалт, анхаарах асуудал” сэдэвт, Улсын бүртгэлийн ерөнхий газрын тамгын газраас бодлого төлөвлөлт, дүн шинжилгээний мэргэжилтэн Ө.Уянгын “Төрийн жинхэнэ албан хаагчын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлагналт, анхаарах асуудал” сэдэвт сургалтанд хэлтсийн албан хаагчид бүгд хамрагдсан.
- 2020.10.03-нд Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын дарга Б.Ариунболдоор ахлуулсан сургалтын баг иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээд, хяналт шалгалтын чиглэлээр тус тус сургалт мэдээлэл өгөв.
- Монгол Улсын Их Хурлын болон Аймаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд Улсын бүртгэлийн байгууллагаас итгэмжлэгдсэн ажилтнаар ажиллах албан хаагчдын Эрх зүйн сургалтыг цахим хэлбэрээр тус тус амжилттай зохион байгуулсан.
- Монгол Улсын Их Хурлын болон Аймаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн итгэмжлэгдсэн ажилтнаар ажиллах албан хаагчдад “Ирц бүртгэлийн програм”-ын сургалтыг амжилттай зохион байгуулсан
- 2020 оны 10 дугаар сарын 06-ны өдөр аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалтанд хэлтсийн 5 албан хаагчийг хамрууллаа.
- 2020 оны 09 дүгээр сарын 14-нд Аймгийн ЗДТГ-с байгууллагын дарга нарын мэдлэг, ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх зорилгоор “Түгээмэл хөгжил төрийн бус байгууллага” –ын зохион байгуулсан арга хэмжээнд хэлтсийн дарга Б.Эрдэнэбилэг оролцсон.
- 2020 оны 10 дугаар сарын 12-ны өдөр Дундговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн зохион байгуулсан онлайн уулзалтанд тус хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн хамт олон оролцож мэдээ мэдээлэл, туршлага солилцлоо.
- 2020 оны 12 дугаар сарын 07-ны өдөр “ZOOM” цахимаар бүх сумын улсын бүртгэгч нарт Тагнуулын хэлтсийн ажилтан Г.Түмэнжаргал “Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалт” сэдвээр, хэлтсийн дарга Б.Эрдэнэбилэг, хяналтын улсын байцаагч Б.Мөнгөнзул нар цаг үетэй холбоотой мэдээлэл, бүртгэлийн зөрчлийн талаар тус тус мэдээлэл өгч ажилласан.
- 2020 оны 11 дүгээр сарын 05-07-ны хооронд Монгол улсын сангийн яам, дэлхийн банкны хамтран хэрэгжүүлж буй “Төсөв санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх” төслийн хүрээнд зохион байгуулагдсан Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг дээшлүүлэх 12 цагийн

багц сургалтанд хэлтсийн ахлах нягтлан бодогч Б. Мөнхдэлгэр хамрагдаж **Сертификат** авлаа.

- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Д. Чимэдцогзол, Мөрөн сумын улсын бүртгэгч Б. Батжаргал, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивч Д. Пүрэвсүрэн нар 2018 онд МҮИС-ийн хууль зүйн сургуулийн Хууль-Эрх зүйн магистрын ангид элсэн орсон бөгөөд хэлтсийн зүгээс тайлант хугацаанд сурах нөхцөл боломжоор ханган ажиллаж, улмаар төгсөлтийн дипломын ажлаа 2020 оны 5 дугаар сарын 05-ны өдөр онлайнаар хамгаалан 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдөр ромбо, дипломоо гардан авлаа.
- 2020 оны 12 дугаар сарын 12-ны өдөр тус хэлтсийн “Эцэг эхийн зөвлөл”-ийн гишүүн Д. Чимэцогзол нь Ковид-19 цар тахлын улмаас хичээл сургуулийн үйл ажиллагааг зогсоосонтой холбогдуулан хэлтсийн нэгдүгээр ангийн хүүхэдтэй эцэг эхчүүдийн дунд “Нэгдүгээр ангийн хүүдийнхээ хичээлийг хэрхэн давтуулж буй туршлага”-аас хуваалцсан арга хэмжээг зохион байгууллаа. Уг сургалтыг Google meet программ ашиглан зохион байгуулсан бөгөөд хэлтсийн 5 эцэг эх хүүхдүүдийн хамт ороцлоо.
- Хэлтсийн дарга Б. Эрдэнэбилэг нь “Аймгийн онцгой комисс”-ын 48 удаагийн хуралд оролцож, хурлаас гарсан шийдвэр, зөвлөмжийн хэрэгжилтийг ханган тухай бүр хэрэгжүүлэн ажилласан байна.

УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗАР

10. СУМДЫН ШИНЭЛЭГ АЖИЛ

Тайлант хугацаанд тус хэлтсийн 23 сум 1 тосгоны Улсын бүртгэгч нар тухайн сумын ЗДТГазрын албан хаагчид болон сумын нийт төрийн албан хаагч нарт Улсын бүртгэлийн багц хуулийн шинэчилсэн найруулгын талаар мэдээлэл өгч зарим сумын ЗДТГазрын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгуулан ажиллаж байна. 2020 онд дэлхий даяар шинэ коронавирусын халдвар гарсантай холбогдуулан тус хэлтсийн 23 сум, 1 тосгоны улсын бүртгэгч нар бүртгэлийн үндсэн үйл ажиллагаанаас гадна бусад төрийн албан хаагчдаа манлайлан дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Мөн улсын бүртгэлийн байгууллагын түүхт 80 жилийн ойн хүрээнд олон сайхан шинэлэг ажлууд хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Улаан-Уул сумын Улсын бүртгэгч Т.Энхбаяр улсын бүртгэлийн үйлчилгээ авч буй иргэдэд тав тухтай орчин бүрдүүлж өөрийн суудаг өрөөг сумынхаа Нийгмийн бодлогын ажилтантай хамтран хувийн хөрөнгөөр тохижуулсан.
- Галт сумын Улсын бүртгэгч С.Дэлгэрмөрөн, Цагааннуур сумын Улсын бүртгэгч М.Цэцгээ нар дэлхий нийтийг цочирдуулан түгшээж байгаа аюулт (Ковид-19) вирус өвчнөөс урьдчилан сэргийлэх, ард иргэдэд цэвэр тохитой орчинд төрийн үйлчилгээ үзүүлэх зорилгын хүрээнд албан ажлынхаа өрөөнд их цэвэрлэгээ хийж, өөрийн хөрөнгөөр эмнэлгийн мэргэжлийн ажилтнаар ариутгал халдваргүйжүүлэлтийг хийлгэсэн.
- Түнэл сумын Улсын бүртгэгч Д.Жаргалмаа Тамгын газрын эмэгтэйчүүдтэй хамтарч коронавирусээс хамгаалах хэрэгсэл болох амны хаалт 380 ширхэгийг оёж иргэдэд хүргэсэн. Мөн Их-Уул сумын Улсын бүртгэгч П.Отгонбаяр өөрийн гараар 150 ширхэг амны хаалт оёж иргэд үйлчлүүлэгчдэд түгээн ажилласан.
- Арбулаг, Жаргалант, Цагаан-Үүр, Цагаан-Уул, Тосонцэнгэл сумдын улсын бүртгэгч нар сумын ЗДТГ-ын хамт олондоо витаминжуулалтын аян зохион байгуулж мөн үйлчилгээ авч буй иргэдэд өөрийн гараар оёсон амны хаалтыг тараан, үйлчлүүлэгчдийн гарыг ариутгаж ажилласан.
- Баянзүрх сумын Улсын бүртгэгч м.Одхүү дэлхий нийтийг түгшээж байгаа аюулт ковид19 вируснээс урьдчилан сэргийлэх зорилгоор бусдыгаа манлайлан иргэний болон тангараг өргөсөн албан хаагчийнхаа үүргээ гүйцэтгэн сумын эрүүл мэндийн байгууллагынхаа албан хаагчдад хувийн зүгээс маск, гар ариутгагчаар хандив өргөсөн.
- Цагаан-Уул сумын Улсын бүртгэгч Д.Ичинхорлоо бүртгэлийн үйлчилгээ авахаар ирсэн иргэдийн гарыг гар ариутгагчаар ариутган, амны хаалт тарааж, шинэ коронавирусийн халдвараас сэргийлэн ажилласан.

- Төмөрбулаг сумын Улсын бүртгэгч Д.Пүрэвдорж нь төрийн албан хаагчийн тангараг өргөсөн албан хаагчийнхаа үүргийг нэр төртэйгээр гүйцэтгэж байгаа сумын цагдаа болон багийн засаг даргад гэр бүлийн зүгээс гар хийцний 20 ширхэг амны хаалт, мөн өөрийнхөө ажилаар үйлчлүүлж байгаа амны хаалтгүй иргэд 3 өдрийн турш 18 удаа маск өгч ажилласан.
- Эрдэнэбулган сумын Улсын бүртгэгч С.Тэмүжин коронавирусаас урьдчилан сэргийлж Улсын бүртгэлийн хэлтсийн нийт ажилчдын дархлааг дэмжих үүднээс хамт олондоо витаминлаг аарц хувийн зүгээс бэлтгэн өгсөн.
- Жаргалант сумын улсын бүртгэгч Ө.Түвшинсайхан тус суманд өвөлжилт хүнд байгаатай холбогдуулан Эмэгтэйчүүдийн холбоо, волейболын холбоотойгоо хамтран хандив цуглуулж нийт 260.000 төгрөгийг малчиддаа хандивлан байгалийн бэрхшээлийг даван туулахад нь багахан ч гэсэн дэм үзүүлсэн.
- Нийт хэлтсийн хамт олны зүгээс Шинэ-Идэр сумын Улсын бүртгэгчээр ажиллаж байсан Аймгийн нэгдсэн эмнэлгийн Дотрын тасагт хэвтэн эмчлүүлж байгаа иргэн Л.Намнандоржид эмчлгээнд нь зориулж дэмжлэг үзүүлэх зорилгоор хэлтсийн албан хаагчдаас 100 000 төгрөг хандивласан.
- Хатгал тосгоны улсын бүртгэгч Д.Сайнбаяр тус тосгоны зорилтот өрх Ч.Агваанчогдонгийн хүүхдийн бичиг баримтыг зөрчилгүй болгох, шинээр 16 нас хүрч байгаа 2 хүүхдийн иргэний үнэмлэх төлбөрийг хариуцан иргэний үнэмлэхийг захиалуулах нийт 45.000 төгрөгийг хувиасаа зарцуулан зорилтот өрхийн иргэнийг бичиг баримтжуулан ажилласан.
- Алаг-Эрдэнэ сумын Улсын бүртгэгч Б.Болормаа Зорилтот бүлгийн хөгжлийн бэрхшээлтэй өрх толгойлсон эмэгтэй болон 4 настай охинд монгол дээл оёж өгч дэмжлэг үзүүлсэн.
- Бүрэнтогтох сумын улсын бүртгэгч Б.Батмягмар сургууль цэцэрлэгийн насны хүүхдүүд амарч байгаатай холбогдуулан бага насны хүүхдийг гэртээ осол гэмтлээс хамгаалах чиглэлээр заавар зөвлөгөө брошурыг тараасан.
- Цэцэрлэг сумын Улсын бүртгэгч Д.Дэлгэрмөрөн ЗДТГ-ын эмэгтэйчүүдтэй хамтран амжиргааны түвшин доогуур тусламж дэмжлэг авах зайлшгүй шаардлагатай олон хүүхэдтэй өрхийг сонгож, 4-р багийн иргэн О.Баяртогтохынд 260.000 төгрөгний хүнс болон ахуй хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг гардуулав. Мөн галд өртөж, гэр оронгүй болсон 5-р багийн иргэн Ж.Нямбатынд 150.000 төгрөгний эд материалын хандив сэтгэлийн дэм өгч, галд бичиг баримт нь үрэгдсэн иргэн М.Наранхүүгийн цахим үнэмлэхийг үнэ төлбөргүй захиалж, иргэнд үнэмлэхийг нь гардуулан өгсөн. / Улсын бүртгэгч хураамжийг өөрөөсөө гаргасан./

- Цэцэрлэг сумын Улсын бүртгэгч Д.Дэлгэрмөрөн нь Улсын бүртгэлийн байгууллагын түүхт 80 жилийн ойг угтаж, Цэцэрлэг суманд 2020 оны 11дүгээр сарын 01-нээс 2020 оны 12-р сарын 01-ныг хүртэл хугацаанд “Үндэсний бичиг бидний бахархал” аяны зохион байгууллаа. Аяны хүрээнд Засаг даргын тамгын газар, Нийгмийн ажилтан, Улсын бүртгэгч, ЕБС-ийн монгол хэл, уранзохиолын багш нартай хамтран насанд хүрэгчид, сурагчид гэсэн хоёр ангилалаар зохион байгууллаа. Насанд хүрэгчдийн дунд “ГЭР БҮЛИЙН АНДГАЙГ”-г, сурагчдын дунд “МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ АНДГАЙ”-г монгол бичгээр цэвэр сайхан алдаагүй бичих уралдаан зарлаж, нийт 30 гаруй иргэн оролцсон. Комисс бүтээлийг шалгаруулж, насанд хүрэгчид болон сурагчдыг тус бүр 3 байр эзлүүлж, мөн сурагчдын бүтээлээс 2 тусгай байрыг шалгаруулсан байна. Төсөв хөрөнгийг ЗДТГ-аас санхүүжүүлж, нийт 250000 төгрөгний шагнал урамшуулал олгосон. Насанд хүрэгчдын хувьд нас насны иргэдээс маш идэвхтэй оролцож, 50 настай боловсролгүй энгийн иргэн монгол бичгээр ямар гоё алдаагүй бичиж ирүүлснийг хараад Монгол хүн ямар агуу чадвартайг, залуучуудад үлгэр дууриалал болсон энэ сайхан иргэдээр бахархаж, цаашид ийм авъяаслаг мэдлэг чадвартай иргэддээ нээн үе хойчдоо өвлүүлэх ажлыг цаашид зохион байгуулан ажиллах талаар ажлын хэсэг болон удирлагууд төлөвлөлөө.

Энэ аяны хүрээнд Бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааг ард иргэдэд сурталчлан таниулж, Монголын өв соёл, уламжлагдан ирсэн монгол хэл бичгээ зөв сайхан бичих, цаашид үр хойч үедээ өвлүүлэн үлдээхэд энэ аяны зорилго нь оршиж байна.

- Галт сумын улсын бүртгэгч П. Даваадулам нь Гарын авлагыг шинэчлэн төрөл бүрээр хэвлэн мэдээллийн самбар, гарын авлагын тавиур, багийн төв, байгууллагууд дээр байрлуулсан. Мөн ууган хүүхдээ бүртгүүлж буй гэр бүлд талархал болон эсгий үнэг бэлэглэж баяр хүргэж хэвшсэн бөгөөд энэ ажлыг 2017 оноос хойш хэрэгжүүлсэн ба 2020 онд нийт 3 гэр бүлд олгов. Шинээр гэр бүл бүртгүүлсэн иргэдэд гэрлэлтийн гэрчилгээтэй хамт Гэр бүлийн андгай, талархалыг тогтмол гардуулан хэвшсэн бөгөөд 2020 оны 8 сараас хойш 7 гэр бүлд өгсөн байна.

Иргэний андгай өргөх ёслолыг жил бүр уламжлал болгон зохион байгуулсаар ирсэн. Энэ онд өргөн хүрээнд зохион байгуулахаар төлөвлөсөн хэдий ч Ковид-19 өвчний улмаас хойшилсон. Хөл хорионы дэглэмээ баримтлан сумын онцгой штабаас зөвшөөрөл авсны үндсэн дээр цөөн сурагчийг оролцуулан тангараг өргүүллээ. Оролцсон сурагчдад Тангарын хуудас иргэний үнэмлэх, сумын удирдлагуудын үг бичсэн тэмдэглэлийн дэвтэр, үзэгний хамт дурсгав.

“Хишиг өдөр” арга хэмжээг санаачлан амжилттай зохион байгууллаа. Төсвийн бүх байгууллагын удирдлагууд, төрийн үйлчилгээний ажилтан нийт 30 албан хаагч нэг өдрийн хугацаанд ажлын байраа сольж ажилласан. Үүнд: ИТХ-ын дарга И.Амгаланбаатар- Сумын ЭМТ-ийн даргаар, Засаг дарга М.Должинжав- сургуулийн захирлаар г.м

- Галт сумын Улсын бүртгэгч П. Даваадулам нь Улсын бүртгэлийн байгууллага үүсч хөгжсөний 80-н жилийн ойг тохиолдуулан дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.
- 16 настай Иргэний үнэмлэх шинээр захиалах насны хүүхдүүдийн дунд “Монгол улсын иргэний Андгай”, “Би монгол улсын иргэн” сэдэвт шүлгийн уралдаан..
- X-XII ангийн сурагчдын дунд Эссэ бичлэгийн уралдаан
- Насанд хүрэгчдийн дунд болон сурагчдын дунд “Би хос бичигтэн” уралдааныг тус тус зохион байгуулан, шилдэг оролцогчидод шагнал урамшуулал гардуулан өгсөн байна.
- Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв Зүрх багийн Сургууль цэцэрлэгийн цогцолборт иргэнийн бүртгэл, эд хөрөнгийн бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэлийг багтаасан - “Иргэний бүртгэлийн хөтөч” лавлах хавтсыг бэлтгэн байгууллагын дарга нарт гардууллаа. Энэхүү хөтөч хавтас нь тухайн байгууллага дээр тогтмол байршиж байгууллагын албан хаагчид болон тэдний ар гэрийнхэн улсын бүртгэлийн талаарх мэдээллийг олж авах зорилготой юм.
- Үйлчилгээний чанарыг сайжруулах иргэдэд үйлчлэх тав тухтай орчин бүрдүүлэх үүднээс өөрийн хөрөнгөөр өрөөндөө шинээр шалны хулдаас авч модон түшлэгтэй 4 хүний сандал хийлгэж тавьсан.
- Тариалан сумын Улсын бүртгэгч М. Номиндарь нь Улсын бүртгэлийн байгууллагын түүхт 80 жилийн ойн хүрээнд танин мэдэхүйн “АХА” тэмцээнийг сумын нийт иргэдийн дунд зохион байгуулахаар удирдамж боловсруулан удирдамжийн дагуу аха тэмцээнийг зохион байгууллаа. Уг тэмцээний асуултыг танин мэдэхүйн асуултаас гадна улсын бүртгэлийн хууль тогтоомжтой холбоотой асуултуудыг оруулж өгснөөр иргэдийг бүртгэлийн байгууллагын талаарх мэдээ мэдээллээр хангах боломж бүрдсэн юм.
- Шинэ-Идэр сумын Улсын бүртгэгч Б. Бямбажав нь сумын ЗДТГ-с эрхлэн гаргасан Шинэ-Идэрийн мэдээ сонинд улсын бүртгэлийн үйлчилгээний талаарх мэдээлэл, тоон мэдээг бэлтгэн нийтлүүлсэн. Мөн Онлайн сүлжээнд холбогдох ажлын бэлтгэл ажлыг хангуулах үүднээс 2020 оны сумын засаг даргын үндсэн чиглэлд 1500.000 төгрөг тусгуулан DELL-15 загварын нөүбтүүкээр хангуулсан байна. Улсын бүртгэлийн байгууллага үүсч хөгжсөний түүхт 80 жилийн ойд зориулан сумын өрхийн дунд “Гэр бүл-бидний үнэ цэн” уралдааныг ажлын хэсэг байгуулан зохион байгуулав.
- Алаг-Эрдэнэ сумын улсын бүртгэгч Б. Болормаа нь Улсын бүртгэлийн байгууллагын үүсэл хөгжлийн талаар 12 дугаар ангийн сурагчдад мэдээлэл хийж бүртгэлийн байгууллагын үйлчилгээний талаарх ойлголтыг бататгах кейс ажиллуулав.
- Сумдын улсын бүртгэгч нар сумын ЗДТГазар, ЕБСургуультай хамтран “иргэний андгай өргөх ёслол” зохион байгуулж, сурлага хүмүүжлээрээ бусдыгаа манлайлсан сурагчдыг шагнаж урамшуулсан.

- Улсын бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний 80 жилийн ойн хүрээнд сумын улсын бүртгэгч нар “Танд зөвлөө” аян өрнүүлж хөдөө сумын төвөөс алслагдсан айл өрхүүдээр орж улсын бүртгэлийн үйлчилгээг сурталчлан, бүртгэлийн үйлчилгээг үзүүлэн ажилласан байна.
- Мөн Чандмань-Өндөр сум, Цэцэрлэг сумын улсын бүртгэгч нар **“Чандмань-Өндөр сумын улсын бүртгэл”, “Цэцэрлэг сум улсын бүртгэл”** гэсэн facebook хуудас нээж бүртгэлийн үйл ажиллагаа мэдээ, мэдээллийг түгээн ажиллаж байна.
- Хатгал тосгоны Д. Сайнбаяр нь Хатгал тосгоны захирагчийн захирамжийн дагуу хүүхэд хамгаалах багт томилогдон ажилладаг бөгөөд хамтарсан багаас бичиг баримтын зөрчилтэй өрхийн судалгааг гаргаж төлбөрийн чадваргүй нэг өрхийн бичиг баримтын зөрчлийг арилгаж эцэг тогтоох бүртгэл, гэрчилгээ олгох, иргэний үнэмлэх захиалах төлбөрийг өөрөөсөө гаргаж /30000 төг/ туслалцаа үзүүлэн ажиллалаа.
- Баянзүрх сумын улсын бүртгэгч М.Одхүү бүх нийтийн хөл хорио дэглэмийн үед тус сумын Бэлтэс 5-р багт оршин суух өрх толгойлсон ганц бие өндөр настай М.Бумаа, Б.Чулуунбаатар нарт өөрийн унаагаар ундны усны мөс ачиж өгч сайн үйлсийн аяныг эхлүүллээ. Тус аяныг сумын иргэд сайшааж 5000 төгрөгийн хандив цуглуулж амьжиргааны түвшин доогуур айл өрхөд гурил, хүнсний бараа материал өгөх аян болон үргэлжилж байна.
- Улаан-Уул сумын улсын бүртгэгч Т. Энхбаяр нь ЗДТГ-ын хийж хэрэгжүүлсэн ажлаа тайлагнах сонин хийх ажлын хэсэгт орж эх бэлтгэлийг хийсэн бөгөөд тус сонинд өөрийн ажлын талаар мэдээ, мэдээлэл нийтлэн ажиллаж байна.
- Ханх сумын улсын бүртгэгч Р. Нэргүй нь сумандаа “ГЭР БҮЛ-ХАЙРЫН ЕРТӨНЦ” залуу гэр бүлийн дунд өдөрлөг зохион байгуулж ШИНЭ ГЭР БҮЛ-д гэрлэлтийн тангараг өргүүлэн “ГЭР БҮЛ-ХАЙРЫН ЕРТӨНЦ” цуврал лекц уншлаа.

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗАР**

11. ДУГНЭЛТ

Тус хэлтэс нь өдөр тутмын үйл ажиллагаандаа Улсын бүртгэлийн ерөнхий хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, хөдөлмөрийн дотоод журам, үйлчилгээний стандартыг мөрдөн ажиллаж, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх болон 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг бүрэн хэрэгжүүлэх талаар онцгой анхаарч холбогдох ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Мөн УБЕГ-т тайлагнах холбогдох эрх зүйн акт, тайлан мэдээг сар, улирал, хагас жил, бүтэн жилээр гаргаж хуулийн хугацаанд хүргүүлэн ажилласан байна.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан төсвийн сахилга батыг сайжруулж, үр ашиггүй зардлыг танах, хэмнэлтийн горимд шилжүүлэх замаар төсвийн алдагдлыг бууруулах тухай заалт, Хууль зүй, Дотоод хэргийн сайд болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаас өгсөн үүрэг даалгавар, чиглэлийн дагуу батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж, урсгал зардлыг бууруулах шат дараалсан арга хэмжээг авч ажиллаж байна.

Хэлтсийн хэмжээнд үйл ажиллагааны урсгал төсөв 661186.3 мян/төгрөг батлагдсанаас 2020 оны 12 сарын 10-ны байдлаар 667972.8 мян төгрөгийн санхүүжилт хийгдэж албан хаагчдын цалингийн зардал хүрэлцэхгүй байгааг шийдвэрлүүлэхээр УБЕГазарт санал хүргүүлж тухайн жилийн төсөвт 6786.5 мян.төгрөгийн санхүүжилтыг цалингийн зардал дээр нэмж хуваарилуулан цалин болон бусад зардалтай холбоотой ямар нэгэн өглөггүй ажиллаж байна. Батлагдсан төсвийг хуваарийн дагуу зарцуулж, байгууллагын өдөр тутмын санхүүгийн үйл ажиллагааг тасралтгүй тогтмол явуулж, нягтлан бодох бүртгэлийн болон анхан шатны бүртгэл хөтлөлтийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийж гүйцэтгэсэн.

Мөн байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос 2020 оны 12 сарын 10-ны байдлаар 164843.1 мян/төгрөгийн орлогыг оруулж улсын төсөвт төвлөрүүлж, 2020 оны 11 сарын 30-ны байдлаар улсын тэмдэгтийн хураамж 49584,0 мян/төгрөгийг сумын төсөвт, 111696,4 мян/төгрөгийн үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсан орлогыг аймгийн төсөвт оруулсан байна.

Тус хэлтэс нь 2019 оны санхүүгийн үйл ажиллагаагаар аймгийн “Санхүүгийн зөрчилгүй “ байгууллагаар шалгарч 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдөр Аймгийн засаг даргаас шагналаа хүлээн авлаа.

Нийт бүртгэлийн тоог 2019 онтой харьцуулахад шинэ короновирус буюу ковид-19 цар тахал гарсантай холбоотойгоор бүртгэлийн тоо буурсан үзүүлэлттэй байна. Мөн байгууллагын сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан танхимын сургалтуудыг онлайнаар зохион байгуулан ажилласан ба сургалтын төлөвлөгөө 100% биелсэн үзүүлэлттэй байна.

Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс

Тус хэлтэс нь 2020 оны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг үе шаттайгаар бүрэн хийж хэрэгжүүлэхээр зорилго тавин ажиллаж төлөвлөгөөт ажлуудаа амжилттай хэрэгжүүлснээс гадна цаг үеийн болон бусад шинэ шинэлэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн ололт амжилт ихтэйгээр 2020 оныг үдэж байна.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
УЛСЫН БҮРТГЭГЧ

Д.ЧИМЭДЦОГЗОЛ

ХЯНАСАН:
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЭРДЭНЭБИЛЭГ

Мөрөн 2020.12.14

